

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ
(Үндэсний бөх)

Удиртгал

Нэг.Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж

Хоёр. Үнэлгээний хэсэг

2.1.Үндэсний бөхийн барилдааны холбогдох хэсэг;

2.2.Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах болон салбар хорооны бүрэн эрхтэй холбогдох хэсэг;

2.3.Бөхчүүдийг сэргээшийн шинжилгээнд хамруулахтай холбогдон гарч буй асуудал;

2.4.Үндэсний их баяр наадмын тухай хууль зөрчигч /бөх/-д хүлээлгэх хариуцлагатай холбогдох хэсэг.

Удиртгал

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндэсний баяр болох Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг хуульчлаагүй наадмын олон талт харилцааг зөвхөн уламжлал дээр тулгуурлан явуулж байгааг өөрчлөх шаардлагын үүднээс 5 бүлэг, 16 зүйлтэй хуулийн төслийг боловсруулсан байдаг. Улмаар Улсын Их Хурлаас 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Үндэсний их баяр наадмын тухай хуулийг баталсан¹ бөгөөд өнгөрсөн хугацаанд тус хуульд 7 удаагийн нэмэлт, өөрчлөлт, зарим хэсэг, заалтыг хүчингүй болгосон байна.

Үүнийг доорхи хүснэгтээр багцлан харуулбал:

Анх батлагдахдаа	Одоо	Шинээр нэмсэн	Өөрчлөн найруулсан	Хүчингүй болгосон
16 зүйл, 89 хэсэг, заалт	16 зүйл, 103 хэсэг, заалт	Нийт 11 хэсэг, заалт (7.1.7, 7.1.8, 7.2, 7.3, 7.4, 7.6, 7.10, 8.7, 8.8, 8.9, 9.3)	20 хэсэг, заалт (7.1, 7.1.1-7.1.9, 7.2, 7.3, 7.5, 7.9, 8.5, 10.2, 12.4.5, 14.3, 7.1.8, 9.2)	6 хэсэг, заалт (16.3, 7.1.7, 11.1.2, 7.1.7, 7.1.8, 7.3)

2007.07.06-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч хэсэгчлэн хориг тавьсан бөгөөд Улсын Их Хурал 2007.08.02-ны өдөр хоригийг хүлээн зөвшөөрч², Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан³.

Мөн 2013.07.05-ны өдөр баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч 2013.07.08-ны өдөр бүхэлд хориг тавьсан⁴. Уг хориг тавьсан үндэслэл нь “*Үндэсний их баяр наадмын тухай хуулийг олон улсын жишиг, өнөөгийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан нийт ард иргэдээр нээлттэй хэлэлцүүлж, мэргэжлийн байгууллагуудын саналыг авч, өргөн хүрээнд шинэчлэн найруулах нь зүйтэй*” гэж захирамж гаргасан байдаг. Улсын Их Хурал 2013.07.09-ний өдөр хоригийг хүлээн зөвшөөрч⁵, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан⁶.

2004 оноос хойшхи нэмэлт, өөрчлөлтүүдийн хувьд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн “Үндэсний бөхийн барилдаан”-тай холбоотой хэсэгт өөрчлөлт ихээхэн орсон байдаг. Иймд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг дараах хэсгүүдэд багцлан хувааж хийв:

¹ Үндэсний их баяр наадмын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2003.06.30-ны өдрийн №24 дугаарт нийтлэгдсэн.

² Ерөнхийлөгчийн хоригийн тухай. 2007.08.02-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 55 дугаар тогтоол. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2007.08.21-ний өдрийн №31 дугаарт нийтлэгдсэн.

³ 2007.08.02-ны өдөр батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2007.08.21-ний өдрийн №31 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013.07.08-ны өдрийн Е/04 дугаартай захирамж. “Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хориг тавих тухай”

⁵ Ерөнхийлөгчийн хоригийн тухай. 2013.07.09-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 50 дугаар тогтоол. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2013 оны №28 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль. 2013.07.09. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн. 2013 оны №28 дугаарт нийтлэгдсэн.

1.Үндэсний бөхийн барилдааны холбогдох хэсэг (7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.8, 7.9 дэх хэсэг);

2.Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах болон салбар хорооны бүрэн эрхтэй холбогдох хэсэг (12 дугаар зүйлийн 12.4.1, 12.4.5 дахь заалт);

3.Бөхчүүдийг сэргээшийн шинжилгээнд хамруулахтай холбогдон гарч буй асуудал (10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг);

4.Үндэсний их баяр наадмын тухай хууль зөрчигч /бөх/-д хүлээлгэх хариуцлагатай холбогдох хэсэг (14 дүгээр зүйлийн 14.1-14.3 дахь хэсэг).

Судалгааны зорилго:

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн Үндэсний бөхийн барилдаантай холбогдох зарим зүйл, заалтын зохицуулалт анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, практик хэрхэн хэрэгжиж байгаа, тэдгээрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох, урьдчилан тооцоолоогүй бусад үр дагавар гарсан эсэхийг тодорхойлох;

Хуулийн цаашдын үр дагавар, нөлөөллийг илрүүлэн гаргаж цаашид хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхэд дүгнэлт өгөх.

Судалгаа хийсэн байдал:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3- т "... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасан. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн хэрэгжилтийн /Үндэсний бөхийн барилдаан/ үр дагаврыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг удирдлага болгон гүйцэтгэв.

Судалгааг гүйцэтгэхдээ хууль тогтоомжийн хувийн хэрэг, хуралдааны тэмдэглэл, эрх зүйн харьцуулалтын арга, шүүхийн практик судлах, тайлан, статистикийн тоо баримтад дүн шинжилгээ хийх, хуулийг хэрэгжүүлэн ажиллаж буй Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо /УИБНЗБХ/-ны шийдвэр, гадаад орнуудын зарим туршлага зэргийг ашигласан болно.

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Үндсэн судлаач Б.Төрболд

"Оюуны-Инноваци" ТББ-ын судлаач,
хуульч

Үндсэн судлаач Н.Оюун-Эрдэнэ

Монголын Хуульчдын холбооны
гишүүн, хуульч

Нэг. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Нэг.Үндэсний бөхийн барилдааны холбогдох хэсэг:

1.Бөхийн цол олгох асуудалд

2007 онд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсан бөгөөд уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын арслангаас бага цолтой бөх 9 давсан бол үзүүр түрүүний барилдааны өмнө түүнд улсын арслан цол олгож, улмаар 10 давж түрүүлбэл улсын аварга цол олгоно” гэж заасан. Уг нэмэлт, өөрчлөлт батлагдсанаас хойш 2011, 2016 онуудад 1024 бөх барилдсан бөгөөд улсын арслангаас бага цолтой бөх 10 давж түрүүлж аварга цол хүртсэн байдаг⁷.

1024 бөх барилдахтай холбоотой ганц зохицуулалт нь дээрх 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг байгаа бөгөөд энэхүү зохицуулалт нь зөвхөн арслангаас доош цолтой бөхөд зориулагдсан зохицуулалт байна. Арслан цолтой бөх ес даван үзүүрлэх, 10 даван түрүүлбэл ямар цол олгох талаар зохицуулагдаагүй бөгөөд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д “арслан цолтон түрүүлсэн бол улсын аварга” цол олгоно гэж заасан⁸. 1024 бөх барилдсан тохиолдолд хэрхэн цол олгох зохицуулалтгүй үлдсэн.

Иймд 1024 бөх барилдах үед арслангаас дээш цолтой бөх үзүүрлэсэн, түрүүлсэн тохиолдолд ямар цол олгохыг тодорхой зааж өгөх хэрэгтэй бөгөөд уг харилцааг зохицуулсан дараах нэмэлт, өөрчлөлтийг хуульд оруулах.

Санал: “Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын баяр наадамд түрүүлсэн арслан цолтой бөх⁹ 9 давсан бол үзүүр түрүүний өмнө түүнд улсын аварга цол олгож, улмаар 10 давж түрүүлбэл улсын даян аварга цол олгоно. Улсын аварга цолтой бөх 9 давсан бол үзүүр түрүүний өмнө түүнд даян аварга цол олгож, улмаар 10 давж түрүүлбэл дархан аварга цол олгоно” .

Ирэх 2021 онд Тулгар төрийн 2230, Их Монгол Улсын 815, Ардын хувьсгалын 100 жилийн ойн Үндэсний их баяр наадам болно. Түүхэн 100 жилийн ойн баяр наадамд 2048 бөх барилдахаар болбол цолыг хэрхэн олгох асуудлыг мөн тодорхой хуульд нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

2.Бөхийн цолны эрэмбийн асуудалд

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д “Үндэсний бөхийн барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхчүүдийг цолны болон амжилтынх нь эрэмбээр тулгаж барилдуулах бөгөөд бусад даваанд дээрх эрэмбээр ам авч барилдана” гэж заасан бөгөөд уг хуулийн 7.9-д “Энэ хуулийн 7.8-д заасан амжилтын эрэмбээр ам авах заалт нь дархан аварга цолтонд хамаарахгүй” гэж заасан. Эндээс үзвэл дархан аварга цолтонд эрэмбийн асуудал хамаарахгүй нөхцөл байдал үүссэн байна.

⁷ 2011 онд улсын харцага С.Мөнхбат, 2016 онд улсын заан Ч.Санжаадамба нар 10 даван түрүүлж, улсын аварга цол хүртсэн.

⁸ Манай улсад өмнө нь 1991 онд 512 бөхөөс улсад түрүүлсэн О.Балжиннямд арслан, 1994 онд 768 бөхөөс ес даван үзүүрлэхэд 1995 онд аварга цол нөхөн олгосон жишиг байдаг.

⁹ Түүхэн уламжлал талаасаа улсын баяр наадамд түрүүлсэн бөхөд аварга цол олгох зарчим Үндэсний их баяр наадмын тухай хууль болон тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн агуулгад байсан болно. Б.Т.

Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор баталсан Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 2.4, 3.1, 3.2-т дээрх харилцааг зохицуулжээ.

Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 3.1-д “Бөхийн барилдааныг бөхчилсөн хэлбэрээр явуулах бөгөөд барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхийн цолны болон амжилтын эрэмбээр тулгаж, бусад даваанд дээрх эрэмбээр, дархан аварга цолтнууд цолны эрэмбээр ам авч барилдана” гэж заажээ. Уг заалтыг харвал Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7.9-д заасан амжилтын эрэмбээр ам авах заалт нь дархан аварга цолтонд хамаарахгүй гэсэнтэй нийцэхгүй байна. Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 3.2-т “Ижил цолтой бөхчүүд энэ дүрмийн 2.4.1, 2.4.2-т заасны дагуу тогтоосон эрэмбээр ам авна” гэж нарийвчлан зохицуулжээ. Уг заалтын дагуу ам авахад дүрмийн 2.4.1-д заасан цол, амжилтаар эрэмблэхэд хэд хэдэн эрэмбийн шалгуурыг тусгасан байна.

Үүнээс үүдэн нэг өдөр дархан аварга цолны болзол хангасан бөхчүүдийн хувьд цол, амжилтын эрэмбэ хамаарах уу? гэх асуудлыг Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулж чадаагүй байна. Мөн Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэмд энэ асуудлыг тодорхой ойлгомжтой байдлаар зохицуулаагүй байна.

2.2. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах болон салбар хорооны бүрэн эрхтэй холбогдох хэсэг

1. Зохион байгуулах болон салбар хорооны бүрэн эрхтэй холбоотой асуудалд

Үндэсний баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт Зохион байгуулах хорооны бүрэн эрхтэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд 12 дугаар зүйлийн 12.4.1-д улсын баяр наадамд үзүүлсэн амжилтыг үндэслэн **бөх**, уяач, харваачид үндэсний спортын¹⁰ төрлөөр улсын цол олгох, хасах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх, 12.4.5-д бөх, харваачийг энэ хуулийн 10.2-т заасан сэргээшийн шинжилгээнд оруулах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой гаргасан ҮИБНЗБХ-ны тогтоолтой холбоотой гомдлууд практикт гарч байна.

Тухайлбал, шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэрэг маргааны хувьд ҮИБНЗБХ-ны шийдвэрүүдтэй холбоотой маргасан байна¹¹.

¹⁰ Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “үндэсний спорт” гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний онцлог шинжийг агуулсан спортыг гэж тодорхойлсон. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2017.11.22-ны өдрийн №43 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ -Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны тогтоол гаргах бүрэлдэхүүнтэй холбоотой;

-Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо Хууль бус захиргааны акт гаргасан. Өөрөөр хэлбэл өөрийн чиг үүрэгт хамаарахгүй асуудлаар захиргааны акт гаргасан;

-Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй тул хүчин төгөлдөр үйлчлэх эрх зүйн чадамжгүй;

-Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны тогтоол нь эрх хэмжээний хувьд зохион байгуулах хороонд хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан, сонсох ажиллагаа хийгээгүй гэх мэт үндэслэлээр бөхчүүд шүүхэд нэхэмжлэл гаргаж, ҮИБНЗБХ-г хариуцагчаар татан оролцуулжээ.

ҮИБНЗБХ-ны шийдвэртэй холбогдуулан гаргасан хэрэг маргаанд нэхэмжлэл гаргасан бөхчүүд нь бүгд сэргээш /допинг/ хэрэглэсэн болох нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон байдаг бөгөөд сэргээшийн шинжилгээний хариу, дүгнэлттэй холбоотойгоор маргасан тохиолдол дийлэнх олонхид байхгүй байв. Харин ҮИБНЗБХ-ны бүрэн эрхээ хэрэгжүүлэн гаргасан захиргааны актад гомдол гаргаж байгаа практик байна.

Үндэсний их баяр наадмын бөхийн барилдааны дүрмээр ҮИБНЗБХ-ны бүрэн эрхэд хамаарах асуудлыг Үндэсний бөхийн салбар хорооны бүрэнд эрхэд хамааруулан хооронд нь давхцуулж, ойлгомжгүй байдал үүсгэж, практикт маргаан үүсэх шалтгааны нэг болж байна. Уг асуудлыг лавшруулан судалж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Санал: Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн “9.3.5.сэргээш хэрэглэсэн нь олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон бол тухайн бөхийн наадамд давсан давааг хүчингүй болгож, шинээр олгосон цолыг хураах, цол, чимэг авах даваанд уг бөхөд унасан бөхчүүдийг тухайн даваанд давснаар тооцож, зохих цол, чимгийг олгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхээр санал гаргах” гэж найруулах.

2.Сэргээшийн шинжилгээнд оруулах ажлын зохион байгуулалтын асуудалд

ҮИБНЗБХ-ны 2007 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан Бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байдаг. Мөн 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 04 дугаартай тогтоолоор “*Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам*”-ыг шинэчлэн баталсан журам нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй талаарх мэдээлэл байхгүй байна.

Иймд дээрх журам нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан Захиргааны хэм хэмжээний актын¹² шинжийг бүрэн агуулж буй тул заавал улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж, хүчин төгөлдөр үйлчилж, сэргээшийн шинжилгээ авах харилцааг зохицуулах тул бүртгэлгүй гэх шалтгаанаар дээрх нөхцөл байдлуудтай холбоотой хэрэг маргаан гарахыг үгүйсгэхгүй юм.

2.3.Бөхчүүдийг сэргээшийн шинжилгээнд хамруулахтай холбогдон гарч буй асуудал

1.Хуулиар сэргээшийн шинжилгээнд хамруулах асуудалд

Үндэсний их баяр наадмын тухай хуулиар нарийвчлан зохицуулаагүй зохицуулалтыг Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор баталсан Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 15.1-т “*Баяр наадмын бөхийн барилдаанд тав болон түүнээс дээш давж шөвгөрсөн бөхчүүд сэргээшийн шинжилгээнд заавал орно*” гэж тодорхой зохицуулсан байна.

¹² Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.

Иймд Үндэсний баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Санал: Үндэсний баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг **“Энэ хуулийн 7.1, 7.2-т заасан барилдаанд 5 давж шөвгөрсөн бөх,...”** гэж өөрчлөн найруулах.

2.Эмчилгээний зорилгоор сэргээшийн шинжилгээнээс чөлөөлөгдөх асуудалд

Эмчилгээний зорилгоор сэргээшийн шинжилгээнээс чөлөөлөх олон улсын стандарт болон Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журмыг нэг агуулгаар ойлгогдох байдлаар тодорхойлж, зохицуулах шаардлагатай байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулаагүй үндэсний спорттой холбоотой бусад харилцааг Биеийн тамир, спортын тухай¹³ хуулиар зохицуулахаар хуульчилсан бөгөөд тус хуулийн 21 дүгээр зүйлд Допингийн¹⁴ эсрэг үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулсан байна. Уг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, спортын холбоо бусад төрийн болон төрийн бус байгууллага нь хориглосон жагсаалтад багтсан бодис, аргууд, допингийн хор холбогдлын сурталчилгааг тогтмол зохион байгуулна гэж заажээ.

Биеийн тамир, спортын тухай хуульд заасан допингийн хор холбогдлын сурталчилгааг тогтмол зохион байгуулах. “Тогтмол” гэдэг нь ямар хугацааг ойлгох, ямар арга хэлбэрээр зохион байгуулах, хэрхэн баталгаажуулж авч байгаа нь тодорхойгүй тул уг асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

2.4.Үндэсний их баяр наадмын тухай хууль зөрчигч /бөх/-д хүлээлгэх хариуцлагатай холбогдох хэсэг

Хариуцлагын асуудлыг оновчтой зохицуулсан асуудалд

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан үүргийг зөрчсөн бөх, ... дараах шийтгэлийн аль нэгийг ногдуулна: 14.1.1. тухайн баяр наадамд оролцуулахгүй байх буюу тухайн баяр наадмын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, үндэсний сурын харваанаас хасах; 14.1.2. тухайн баяр наадмын бай, шагналыг олгохгүй байх; 14.1.3. баяр наадамд оролцох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах” гэж заасан.

Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Баяр наадамд оролцож буй бөх үндэсний бөхийн барилдааны дүрэмд заасан үүргийг биелүүлж, цээрийг сахих үүргийг хүлээнэ.” Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор баталсан Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 8.2-т бөхийн үүргийн талаар тусгасан. Тус нийтлэг үүрэг нь барилдааны дүрмийг судлан мэдэх, сахин биелүүлэх, бөхийн өмсгөлийн

¹³ Биеийн тамир, спортын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 оны 43 дугаарт нийтлэгдсэн.

¹⁴ Тус хуулийн 4.1.14-т “допинг” гэж спортын үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглосон бодис, хориотой аргыг гэж тодорхойлсон.

шаардлагад нийцсэн өмсгөл хэрэглэх, үзэгч олноо хүндэтгэх, барилдааны явцад хориглосон мэх хийх байхгүй талаар зохицуулсан.

Тэгэхээр Үндэсний их наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан хариуцлагад зөвхөн “үүрэг” зөрчсөн бол шийтгэл ногдуулах, мөн хуулийн тус шийтгэлийг аймаг, сумын салбар хороо болон зохион байгуулах хороо ногдуулахаар байна.

Практикт хууль болон дүрэмд заасан үүргийг зөрчсөнөөс гадна сэргээш хэрэглэсэн бөхчүүдэд 14.1.3-т заасан шийтгэлийг ногдуулсан байна. Сэргээш хэрэглэхийг хориглох талаарх зохицуулалт хууль болон бөхийн барилдааны дүрэмд заасан үүрэгт тусгагдаагүй. Мөн бөхчүүдэд хариуцлага тооцсон арга хэмжээ нь харилцан адилгүй байгаа бөгөөд барилдах эрх хасах хугацааны асуудал нь хууль, дүрэм болон журамд нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Цаашид Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг хэрхэн ногдуулахыг тодорхой тусгах шаардлагатай байна.

Эцэст нь судалгааны үр дүнг үндэслэн судалгааны багийн зүгээс Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу “Үндэсний их баяр наадмын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмжийг өгч байна.

Хоёр. ҮНЭЛГЭЭНИЙ ХЭСЭГ

2.1. Үндэсний бөхийн барилдааны холбогдох хэсэг

Үнэлэгдэх хэсэг	<p>7.1.Улсын баяр наадамд дараах амжилт гаргасан бөхөд дор дурдсан цол олгоно:</p> <ul style="list-style-type: none">7.1.1.тав давсан бөхөд улсын начин;7.1.2.зургаа давсан бөхөд улсын харцага;7.1.3.долоо давсан бөхөд улсын заан;7.1.4.найм давсан бөхөд улсын гарьд;7.1.5.ес даван түрүүлсэн бөхөд улсын арслан;7.1.6.улсын арслан цолтон түрүүлсэн бол улсын аварга;7.1.7.улсын аварга түрүүлсэн бол улсын далай аварга; <u>/Энэ заалтыг 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</u>7.1.8.улсын далай аварга түрүүлсэн бол улсын даян аварга; <u>/Энэ заалтад 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</u>7.1.9.улсын даян аварга түрүүлсэн бол улсын дархан аварга. <p>7.2.Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын арслангаас бага цолтой бөх 9 давсан бол үзүүр түрүүний барилдааны өмнө түүнд улсын арслан цол олгож, улмаар 10 давж түрүүлбэл улсын аварга цол олгоно.</p> <p>7.8.Үндэсний бөхийн барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхчүүдийг цолны болон амжилтынх нь эрэмбээр тулгаж барилдуулах бөгөөд бусад даваанд дээрх эрэмбээр ам авч барилдана.</p> <p>7.9.Энэ хуулийн 7.8-д заасан амжилтын эрэмбээр ам авах заалт нь дархан аварга цолтонд хамаарахгүй.</p>
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	1. Бөхчүүдэд цол олгох асуудлыг Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулж чадсан уу?

Үнэлгээ:

Асуулт: Бөхчүүдэд цол олгох асуудлыг Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулж чадсан уу?

1.Монгол бөхөд цол олгож байсан уламжлал

Монгол бөх нь манай үндэстний ертөнцийг үзэхүй, соёл, урлаг, хэв заншилтай нягт уялдан түүний нэгэн хэсэг болон өргөн цар хүрээтэй хөгжиж байсан ба түүгээр бүхий л эрчүүд /зарим тохиолдолд эмэгтэйчүүд ч барилдаж байсан бололтой/ хичээллэн, бие бялдраа хөгжүүлж, уламжлалт ёс заншлаа хадгалан хөгжүүлсээр ирсэн бөгөөд тэдгээрийн дотроос шалгаран гарсан хүмүүсийг “бөх” хэмээн нэрийдэх болжээ¹⁵. Монгол бөхийн хөгжлийн эхэн үед “бөх” хэмээх томъёолол нь өөрөө цол болон үүссэн байна¹⁶.

¹⁵ Б.Буяндэлгэр. (Ph.D), Монгол бөхийн цолны хувьсал өөрчлөлт. <https://bit.ly/2lUbeq1>

¹⁶ Мөн тэнд. Б.Буяндэлгэр судлаачийн судалснаар. <<XI-XIII зууны үед БӨХ бол Монголын овог аймгийн тэргүүн буюу сурвалжтан байдаг байжээ. Гэвч, БӨХ бол, Дорнод Азийн Монгол хамниган аймагт боловч овог аймгийн тэргүүн байсан бололтой. Жишээ нь: аймгийн эзнээ МОФО, МОХЭ гэдэг байжээ. Тэр МОФО, МОХЭ гэсэн үгийг Монголын БӨХ (бичгийн БӨКЕ, БӨХЭ) гэсэн үгийн Б нь М болсон үг мөн гэж бодож байна... МОФО- V зууны үед, МОХЭ-VI зууны үед, БӨКЭ(БӨХЭ)- XI-XIII зууны үед, БӨХ- XX зууны үед>> Нэг үгээр хэлбэл, арга ухаан, бяраа чадал, овсгоо самбаагаараа овог аймгийнхаа дундаас товойн гарсан хүнийг “бөх” хэмээн цоллож, гол төлөв тэргүүнээрээ сонгодог уламжлалтай байжээ. Улмаар, улсын хэмжээний томоохон наадамд

Судлаач Ц.Шагдаргочоогийн үзсэнээр, XVIII зууны үед Монгол бөхөд начин (5, 6 давсан бөхөд), заан (7 давсан бөхөд), арслан (8 давсан бөхөд), аварга (9 ба түүнээс дээш давсан бөхөд) гэсэн зэрэг дараалал бүхий цолны тогтолцоо үйлчилж байсан бөгөөд эдгээр нь улсын зэрэглэлийн цолууд байсан бол орон нутгийн зэрэглэлд шонхор (5 давбал), харцага (6 давбал), бүргэд (7 давбал), гарьд (8 давбал), шандас (9 давбал) цолуудыг олгож байсан ажээ¹⁷.

1924 оноос наадам явуулах журмыг баталж “БНМАУ-ын дотор олон нийтийн хэв журмаар гүйцэтгэн наадах эрийн гурван зүйлийн тухай дүрэм” дотор Монгол үндэсний бөхийн дүрмийг гаргасан нь түүнийг спортын бие даасан төрөл болохынх нь хувьд дүрэмжүүлэх эхлэлийг тавьсан нь орчин үеийн спортын жишигт нийцсэн үйл явдал болжээ¹⁸. Улмаар уг бөхийн дүрэмд зааснаар <<6 ба 7 давсан бөхчүүдэд начин буюу шонхор буюу бүргэд, эсхүл харцага цол, 8 давснаас үзүүлсэн бөхчүүдэд заан цол, нэг удаа түрүүлсэн бөхөд аварга цол, гурван удаа түрүүлсэн бөхөд дархан аварга цол>> олгохоор заажээ¹⁹.

Энэүү дүрэм нь бичгээр хадгалагдан үлдсэн орчин үеийн Монгол бөхийн анхны дүрэм юм. Улмаар 1934, 1938, 1961, 1969, 1981, 1982, 1984, 1985, 1988 онуудад бөхийн барилдааны дүрэм, барилдах журам, цол олгох дүрэм, журмуудыг удаа дараалан гаргаж Монгол үндэсний бөхийн барилдааныг улам бүр боловсронгуй болгоход ихээхэн түлхэц үзүүлсэн юм.²⁰

1934 оны бөхийн дүрэмд <<барилдсан бөхчүүдээс тэргүүний 16 буюу 32 бөхийг шөвөгт орсон хэмээн онцгой шалгарсанд үзэх ба тэдэнд бай, цол олговоос зохих бөгөөд ... ямар цол олгосон тухайг тодорхойлон тус бөхийн комиссоос тусгай үнэмлэх бичиг олгож хадгалуулах>> гэснээс өөрөөр бөхийн ямар цолууд олгох талаар тодорхой дурьдаагүй²¹ байдаг.

1961 оны бөхийн дүрэмд бөхийн цолны талаар дэлгэрэнгүй дурьдаж²², Улсын их баяр наадамд 5, 6 давсан бөхөд хэрэв урьд нь улсын цолгүй бол улсын начин, 7 давсан бөхөд цолгүй бол заан, 8 давсан бөхөд улсын арслан цол олгох. Мөн улсын алдар цол олгохдоо улсын наадамд 2 удаа түрүүлбэл улсын аварга, 3 дахь удаагаа түрүүлбэл даян аварга, 4 дэх удаагаа түрүүлбэл далай даян аварга, 5 дахь удаагаа түрүүлбэл дархан аварга, 6 дахь удаагаа түрүүлбэл орон даяар дуурсагдах онц гайхамшигт далай даян дархан аварга цол, улсын наадамд начингийн зэргийг 4 жил, зааны зэргийг 3 жил, арслангийн зэргийг 2 жил тус тус хамгаалсан бол түүний амжилтыг тэмдэглэн заан, арслан, аварга цолыг зориуд олгоно гээд оны тэргүүн бөхийг шалгаруулахад аварга цолыг өгөхгүй, харин тэр оны тэргүүн бөх гэж алдар өгнө гэжээ.

түрүүлсэн бөхчүүдийг “хаан” хэмээн цоллож байсан тухай мэдээ баримтыг судлаачид дурдсан байдгийг дурдах нь зүйтэй.

¹⁷ Ц.Шагдаргочоо. Монголын бөх. УБ., (1960) 53-54 дэх тал. дам ишлэв.

¹⁸ Бөх сонин. УБ., 1993. №2.

¹⁹ Е.Бямбаа. Түүхэн эх сурвалж дахь Монгол бөхийн тухай баримт тэмдэглэгээ. УБ., 2015. 91 дэх тал. Үндэсний төв архив. Х-1. Д-6. Хн-348.

²⁰ Б.Буяндэлгэр. Монгол бөхийн барилдааны хөгжлийн түүхэн тойм. Монгол үндэсний бөхийн хөгжил (XX-XXI зуун). <https://bit.ly/36ZoOk5>. 4 дэх тал.

²¹ Б.Буяндэлгэр. (Ph.D), Монгол бөхийн цолны хувьсал өөрчлөлт. <https://bit.ly/2lUbeq1> 3 дахь тал. Их баяр наадмын бөхийн журамтай танилцахтун. “Ардын үндэсний эрх” сонин. 7 сарын 7-ны №153 дугаарт.

²² Үндэсний төв архив. Х-309. Д-3. Хн-198. БНМАУ-ын Монгол үндэсний бөхийн барилдааны дүрэм.

Харин улсын оны тэргүүн бөх шалгаруулах барилдаанд 2 жил дараалан түрүүлбэл уг бөх нь улсын цолгүй бол улсын заан цол олгох ба улсын цолтой бол уг цолыг шат ахиулан өгнө хэмээн заажээ²³.

1969 оны дүрмээр дээрх цолны үндсэн агуулгад өөрчлөлт оруулаагүй боловч <<онцгой тохиолдлоор цолыг дэвшүүлэн олгох асуудлыг жич шийдвэрлэнэ... Бүх орон даяар шалгаруулан барилдуулсан тойргийн барилдаанд шалгарч 1-3 байранд орсон бөхчүүдэд улсын цолыг олгож болно>> гэж тодотгосон²⁴ бол 1981 онд анх бөхийн барилдааны дүрмээс тусдаа бие даасан бөхийн цол олгох журам гаргажээ.

Түүнд дурьдсанаар, <<улсын арслан бөх түрүүлбэл “даян аварга цол”, үзүүрлэвэл “улсын аварга цол”, улсын заан цолтой бөх түрүүлбэл “аварга” цол, 7, 8 давбал “арслан” цол, улсын начин цолтой бөх түрүүлбэл “аварга” цол, үзүүрлэвэл “чин зоригт арслан” цол, 5 давбал чимэг, 6 давбал “улсын заан”, 7, 8 давбал “улсын арслан” цол, аймаг, цэргийн цолтой болон цолгүй бөхчүүд түрүүлбэл “аварга” цол, үзүүрлэвэл “арслан” цол, 5 давбал “улсын начин”, 6 давбал “улсын заан”, 7 давбал “өсөх идэр улсын заан” цол>> олгохоор заасан байна²⁵.

Гэтэл Монгол бөхийн цолыг Монгол Улсын спортын цол, зэргийн нэгдсэн ангилалд багтаан баталсан 1982, 1985 онуудын цол олгох дүрэмд <<түрүүлсэн бөхөд “улсын арслан” цол, ... түүнчлэн сум, аймаг, арми, улсын аварга шалгаруулах тэмцээнд нийтдээ начны болзлыг 5 удаа хангасан бөхөд зохих “заан” цол, зааны болзлыг хангасан бөхөд зохих “арслан” цол>> олгоно гэж зааснаас бусад нь өмнөх журамтай ижил болзолтой юм.

1988 оны бөхийн дүрмээр, наадмаар олгох цолыг өмнөхтэй нэгэн ижил байхаар заасан боловч 1969 оны дүрмийн заалтыг тодотгож <<МБАТС-ын тойргийн барилдаанд 1-3 дугаар байранд шалгарсан бөхчүүдэд улсын цол, чимэг олгоно. Улсын арслан цолыг уналгүй түрүүлсэн бөхөд олгоно. Улсын баяр наадамд түрүүлэн улсын арслан цол авсан бөх МБАТС-дад уналгүй түрүүлбэл улсын аварга цол олгоно. Түүнчлэн спартакиад, улсын аварга шалгаруулах барилдаанд гурван удаа үсүүлчийн удаад нь өвдөг шороодолгүй түрүүлвэл улсын аварга цол олгоно. Улсын начин, заан цолыг спартакиадын зааврын дагуу олгоно. Улсын аварга шалгаруулах тойргийн барилдаанд ... улсын баяр наадмаар заан цол авсан бөх уналгүй түрүүлбэл улсын арслан цол олгоно>> хэмээн заажээ²⁶.

1990 оны Монголын үндэсний бөхийн барилдааны дүрэм гарснаар, бүх ард түмний спартакиад, улс, аймаг, нийгэмлэг, хот, сумын аварга шалгаруулах тэмцээнээр цол өгөхийг болиулж, жилд ганцхан удаа наадмаар цол олгохоор заасан. Мөн тэгш ойн жилүүдэд даваа ахиулан цол олгох явдлыг зогсоосон байна²⁷.

²³ Түүнчлэн, Улсын баяр наадмын хүүхдийн барилдаанд 1-р байр эзлэн түрүүлсэн хүүхдэд улсын шонхор, 2-р байр эзлэж үзүүрлэсэн хүүхдэд улсын харцага, өсвөрийн залуучуудын барилдаанд 1-р байр эзлэн түрүүлсэн бөхөд улсын тулгаат, 2-р байр эзлэн үзүүрлэсэн бөхөд улсын шандас цол. Аймаг, хотын баяр наадамд барилдсан бөхчүүдэд улсын ямар нэг цол олгохгүй, харин аймаг, хотын начин, заан, арслан цол, хүүхэд ба өсвөрийн залуу бөхөд аймаг, хотын хэмжээнд дээрх цол олгож болно хэмээн заасан байна.

²⁴ Ш.Адъяаа, Б.Ерэнтэй. Монгол бөхийн дүрэм. УБ., (2008), 32 дахь тал. дам ишлэв

²⁵ Мөн тэнд. 34 дэх тал

²⁶ Үндэсний төв архив. Х-309. Д-3 Хн-352.

²⁷ Доктор Б.Буяндэлгэрийн судалснаар Монгол бөхийн цолны түүхэн хөгжлийг бүхэлд нь тоймлон ийнхүү ангилсан байна: 1.Үүсэл бүрэлдлийн үе (эртнээс XIII зуун хүртэл), 2.Төлөвшил хөгжлийн үе (XIII зуунаас 1859 он хүртэл), 3.Өөрчлөлт шинэчлэлтийн үе (1859-2000-аад он хүртэл), 4.Эрх зүйт хөгжлийн үе (2000-аад оноос хойш).

2. Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулсан зохицуулалт:

2001 оноос даваа болгоныг цолтой болгох Монгол бөхийн цолны тогтолцоог шинэчлэх асуудлыг Монголын Үндэсний бөхийн холбоо /МҮБХ/-ноос санаачлан, цэцгийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлж байсан.

Улмаар бүх ард түмний, үндэсний их баяр наадмыг тэмдэглэх үйл ажиллагааг уламжлал дээр тулгуурлан зохицуулж байсныг өөрчлөн анх удаа хуульчлан тогтоох, наадмын олон талт харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлж, 2003 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд²⁸ Улсын баяр наадамд <<тав давсан бөхөд улсын начин; зургаа давсан бөхөд улсын харцага; долоо давсан бөхөд улсын заан; найм давсан бөхөд улсын гарьд; ес даван түрүүлсэн бөхөд улсын арслан; улсын арслан цолтон түрүүлсэн бол улсын аварга; улсын аварга түрүүлсэн бол улсын далай аварга; улсын далай аварга түрүүлсэн бол улсын даян аварга; улсын даян аварга түрүүлсэн бол улсын дархан аварга>> цол олгохоор анх удаа хуульчилсан²⁹.

Үндэсний их баяр наадмын тухай хууль батлагдсанаар “улсын харцага, улсын гарьд, улсын далай аварга³⁰” гэсэн шинэ цол бий болсон. Улмаар улсын харцага, улсын гарьд цолыг бий болгосноор даваа бүрт цол олгох, цолны болзол хангасан бөхчүүдэд цолыг шинээр олгох, барилдааны даваа бүрийг өрсөлдөөнтэй болгож, бөхчүүдийн амжилтыг шударгаар үнэлэх боломжийг бүрдүүлэх, хууль батлагдсан жилээс уг цолуудыг олгож эхэлсэн байна.

Гэвч 2003 оноос өмнөх жилүүдийн улсын баяр наадамд улсын гарьд, улсын харцага цолны болзлыг хангасан бөхчүүд цолоо нөхөн авч чадахгүй байдал үүсч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д³¹ үндэсний бөхийн барилдааны гурвын даваанаас эхлэн бөхчүүд цолны болон амжилтын эрэмбээр ам авах тухай заалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч, бөхчүүдийн одоо байгаа цолны дотор эрэмблэн барилдуулбал шинэ харцага цолтноос илүү амжилттай начин цолтон³² тэдний ард босч ам авах нь бөхийн амжилтыг шударгаар үнэлэх, олон зуун жил уламжилж ирсэн бөхийн дэг жаягтай нийцэхгүй байх, шинэ хуулийн ач

²⁸ Үндэсний их баяр наадмын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2003.06.30-ны өдрийн № 24 дугаарт нийтлэгдсэн.

²⁹ Үндэсний их баяр наадмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудал. Хууль санаачлагчийн илтгэлд дурдсан хэсгээс... Улсын баяр наадамд 6 давсан бөхөд улсын харцага, 8 давсан бөхөд улсын гарьд цол олгохоор төсөлд тусгалаа. Ийм цол олгодог эртний уламжлалт Монгол бөхийн түүхэнд байжээ. Энэхүү үндэсний бөхийн барилдааны 5-аас дээшхи даваа бүрт цол олгох эртний уламжлал сэргэж байгаа юм. Үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, үндэсний сурын харвааны дүрмийг Засгийн газар батлахаар төсөлд тусгасан. Спортын томоохон уралдаан, тэмцээний үеэр сэргээшийн шинжилгээ хийдэг олон улсын туршлагад үндэслэн бөх, морь, харваачдад сэргээшийн шинжилгээ хийх заалт төсөлд орсон болно.

Чуулганы нэгдсэн хуралдааны 2003.06.18-ны өдрийн хуралдааны тэмдэглэл.

<http://www.parliament.mn/n/xhfo>

³⁰ 1961 оны бөхийн дүрэмд заасан “4 дэх удаагаа түрүүлбэл далай даян аварга” гэж байсан “далай” гэх чимгийг цол болгожээ.

³¹ Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт ороогүй үеийн 7 дугаар зүйлийн 7.5-д “Үндэсний бөхийн барилдааны гурвын даваанаас эхлэн бөхчүүд цолны болон амжилтын эрэмбээр ам авах бөгөөд амжилтын эрэмбээр ам авах нь аварга цолтонд хамаарахгүй. Дөрвийн даваанд бөхчүүдийг цолны эрэмбээр тулгаж барилдуулна” гэж заасан байсан.

³² Тухайлбал, 2003 оны Үндэсний их баяр наадмын тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө 6 давж начин цол хүртсэн бөхчүүдийн хувьд.

холбогдлыг бууруулж болзошгүй байгаа талаар бөхчүүд, бөх сонирхогчид, санал хүсэлтээ Монгол Улсын Ерөнхийлөгчид удаа дараа ирүүлсэн³³ байдаг.

Иймд асуудлыг зохицуулахын тулд Үндэсний их баяр наадмын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө улсын баяр наадамд 6 давсан бөхөд улсын харцага, 8 давсан бөхөд улсын гарьд цолыг нөхөн олгох нь зүйтэй гэж Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай³⁴, Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, 2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан³⁵.

Уг хуулийн төсөл батлагдсанаар улсын их баяр наадамд үзүүлсэн амжилтыг нь үндэслэн бөхчүүдэд улсын гарьд, улсын харцага цолыг нөхөн олгосон, харин хууль хэрэгжиж эхлэхээс өмнө нас барсан, улсын харцага цолны болзол хангасан нэр бүхий 18 хүнд цол нөхөж олгогдоогүй байна³⁶. Харин улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд 9, 10 давсан бөхчүүдийн амжилт нөхөн үнэлэгдээгүй байсныг 2007 оны 7 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар³⁷ нөхөж олгосон байна³⁸.

2007 онд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас боловсруулж 2007 оны 06 дугаар сарын 21-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн байдаг.

Тус хуулийн төслийн үзэл баримтлал нь Үндэсний бөхийн барилдаанд сэргээш хэрэглэсэн бөхийн сүүлийн давааг хүчингүй болгож, тэр даваанд түүнд унасан бөхийг давсанд тооцож цол, цолны чимгийг нөхөн олгох, сэргээш хэрэглэсэн харваач, хурдан морины байрыг хойшлуулан түүний дараагийн байр эзэлсэн харваач, морины амжилтыг урагшлуулан тооцох. Улс, аймаг, сумын наадамд 1024, 256, 128 бөх барилдсан тохиолдолд олгох цолны болон бөхчүүдийн цол болон амжилтаар эрэмбэлэх асуудлыг илүү тодорхой болгох зэрэг асуудлыг шийдвэрлүүлэхээр төслийг боловсруулж³⁹, 2007 оны 7 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан .

³³ Ерөнхийлөгчийн нийгмийн бодлогын зөвлөх Л.Лхагваагийн Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлын танилцуулга. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. 2004.05.07-ны өдөр.

<http://www.parliament.mn/files/4386>

³⁴ **“1 дүгээр зүйл.** Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын баяр наадамд 6 давсан бөхөд улсын харцага, 8 давсан бөхөд улсын гарьд цолыг тус тус олгоно.

2 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуульд заасан улс, аймаг, сумын цолыг нэхэн олгохгүй” гэж заасан байна. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2004.06.07-ны өдрийн №22 дугаарт.

<http://www.parliament.mn/files/9922>

³⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2004.06.07-ны өдрийн №22 дугаарт нийтлэгдсэн.

³⁶ <http://www.todmagnai.mn/n/1y4> сүүлд 2020.11.30-ны өдөр хандсан.

³⁷ “... Улсын наадамд түрүүлсэн улсын арслан цолтон 10 даван түрүүлсэн бол улсын далай аварга цолыг тус тус олгоно” гэж нэмсэн.

³⁸ Энэ цолыг 2001 онд Ардын хувьсгалын 80 ойн баяр наадамд 10 даван түрүүлсэн улсын аварга А.Сүхбатад 2007 онд даяан аварга цол нөхөн олгосон.

³⁹ Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний их баяр наадмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн үзэл баримтлал. 2007 он.

Уг хуулийн төсөл батлагдсанаар, Ардын хувьсгалын тэгш ойгоор улсын баяр наадамд 1024 бөх, аймгийн баяр наадамд 256 бөх, сумын баяр наадамд 128 бөх барилдах тохиолдол, тухайн жил улсын баяр наадамд улсын арслан цолоос бага цолтой бөх 9 давсан бол улсын арслан цол, тухайн арслан цолтон арав даван түрүүлсэн бол улсын аварга цол олгох⁴⁰, аймаг, цэрэг, сумын наадамд ч илүү давааны амжилтад нь тохирсон цол олгох явдлыг зохицуулсан.

Мөн бөхчүүд ам авахад цолны болон амжилтын эрэмбээр, оноолтоор барилдуулах, зөвхөн цолны эрэмбийг харгалздаг байхаар хуульд заасныг⁴¹ нэг мөр болгож Улсын баяр наадмын Үндэсний бөхийн барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхчүүдийг цол, амжилтын эрэмбээр тулгаж барилдуулах, бусад даваанд цол, амжилтын эрэмбээр ам авч барилдах болсон. Харин энэ амжилтын эрэмбээр ам авах заалт нь дархан аварга цолтонд хамаарахгүй байхаар хуульчилсан.

2007 оны нэмэлт, өөрчлөлтөөр Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т *“Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын арслангаас бага цолтой бөх 9 давсан бол үзүүр түрүүний барилдааны өмнө түүнд улсын арслан цол олгож, улмаар 10 давж түрүүлбэл улсын аварга цол олгоно”* гэж заасан. Уг нэмэлт, өөрчлөлт батлагдсанаас хойш 2011, 2016 онуудад 1024 бөх барилдсан бөгөөд улсын арслангаас бага цолтой бөх 10 давж түрүүлж аварга цол хүртсэн байдаг⁴².

1024 бөх барилдахтай холбоотой ганц зохицуулалт нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг бөгөөд энэхүү зохицуулсан зохицуулалт нь зөвхөн арслангаас доош цолтой бөхөд зориулагдсан зохицуулалт байна. Арслан цолтой бөх ес даван үзүүрлэх, 10 даван түрүүлбэл ямар цол олгох талаар зохицуулагдаагүй бөгөөд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д *“арслан цолтон түрүүлсэн бол улсын аварга”* цол олгоно гэж заасан⁴³. 1024 бөх барилдсан тохиолдолд хэрхэн цол олгох зохицуулалтгүй үлдсэн.

2013 онд Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Х.Баттулга, Г.Батхүү, Н.Батцэрэг, Ц.Баярсайхан, Б.Болор, Х.Болорчулуун, Ц.Оюунбаатар, Я.Содбаатар нарын гишүүд бид Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж Монгол Улсын Их Хуралд 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн байдаг.

Хууль санаачлагчийн илтгэлд⁴⁴, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр цол олгодог болох үед далай аварга цолыг шинээр бий болгосон. Энэ нь Монгол үндэсний бөхөд байгаагүй цол ба харин цолны чимэг байсан түүхтэй. Тийм учраас Монгол үндэсний

⁴⁰ Учир нь ийм жишиг 2006 онд Тулгар төрийн 2215, Их Монгол Улсын 800, Ардын хувьсгалын 85 жилийн ой, Үндэсний их баяр наадмын хүчит бөхийн барилдаанд 10 давж түрүүлсэн Д.Сумъяабазарт Ерөнхийлөгчийн зарлигаар аварга цол олгосон.

⁴¹ 2003 онд батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-т *“Үндэсний бөхийн барилдааны гурвын даваанаас эхлэн бөхчүүд цолны болон амжилтын эрэмбээр ам авах бөгөөд амжилтын эрэмбээр ам авах нь аварга цолтонд хамаарахгүй. Дөрвийн даваанд бөхчүүдийг цолны эрэмбээр тулгаж барилдуулна”* гэж заасан байсан. Төрийн мэдээлэл эмхэтгэийн 2003 оны №24 дугаарт нийтлэгдсэн.

⁴² 2011 онд улсын харцага С.Мөнхбат, 2016 онд улсын заан Ч.Санжаадамба нар 10 даван түрүүлж, улсын аварга цол хүртсэн.

⁴³ Манай улсад өмнө нь 1991 онд 512 бөхөөс улсад түрүүлсэн О.Балжиннямд арслан, 1994 онд 768 бөхөөс ес даван үзүүрлэхэд 1995 онд аварга цол нөхөн олгосон жишиг байдаг.

⁴⁴ Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж 2013 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. <http://www.parliament.mn/files/9698>

бөхийн хөгжил өндөр төвшинд хүрч өрсөлдөөн их болж байгаа энэ үед үндэсний бөхийн дархан аварга төрөх боломж бол хомсдож сүүлийн 23 жил дархан аварга төрөөгүй байгаа юм. Тийм учраас далай аварга цолыг хасах нь зүйтэй гэсэн саналыг энэ хуулиараа та бүхэнд толилуулж байгаа юм. Үүнд: <<найм давж гурван удаа үзүүрлэсэн бөхөд улсын арслан; улсын баяр наадамд арслан цолтой бөх хоёр удаа найм давж үзүүрлэсэн бол улсын аварга; Үндэсний баяр наадмын тухай хуулийн 7.1.8-д заасан “далай аварга” гэснийг “аварга”>> гэж нэмэлт, өөрчлөлт оруулах гэжээ.

Уг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын баяр наадамд түрүүлсэн арслан цолтой бөх ес давбал үзүүр түрүүний барилдааны өмнө түүнд улсын аварга цол олгож, улмаар арав давж түрүүлбэл улсын даян аварга цол олгоно.”, найм давж гурван удаа үзүүрлэсэн бөхөд улсын арслан; улсын баяр наадамд арслан цолтой бөх хоёр удаа найм давж үзүүрлэсэн бол улсын аварга; “далай аварга” цолыг хасах, мөн хуулийг дагаж мөрдөхөөс өмнө энэ хуулиар тогтоосон болзлыг хангасан бөхөд зохих цолыг олгох зохицуулалт орсон байв.

Тохиолдол: *Б.Бат-Эрдэнэ⁴⁵: Энэ цолтой холбоотой юм бол их олон жил яригдсан зүйл л дээ. Тэгээд хуучин тогтолцооны үед бол бас тэгш ойн жил, заримдаа үзэмжээрээ цол олгож байсан, тэгээд дүйцүүлж цол олгоод байсан байгаа юм. Өнөөдрийн энэ хуулийн зохицуулалт бол яг тийм дүйцүүлэх хэлбэрээр цол олгохоор хуульчлаад өгсөн байна л даа. Тэгэхээр энэ бол зөвхөн аварга, арслан том цолтой хүмүүст том цол олгоод бусад хүмүүсийг нь хамаагүй гээд орхичих арга байхгүй. Тэгэхээр энэ асар их маргаантай асуудал байсан учраас дүйцүүлж цол олгох юм уу, даваа болгондоо цолтой байх юм уу гэдэг талаар хэлэлцүүлэг явуулсан юм. Энэ дүйцүүлж цол олгох нь буруу байна гэж олон түмний зүгээс шүүмжлэл гарсан учраас нийтдээ улсын хэмжээний 10 аймаг Улаанбаатар хотыг оролцуулаад ингээд 1000 хүний судалгаа аваад 300 хүнээс амаар асуула асуугаад, тэгээд ерөөсөө дүйцүүлж цол олгох нь буруу байна, дараа болгонд цол олгох ёстой байна гэдэг ийм санал гараад тэгээд Бөхийн холбоо хэлэлцэж байгаад дүйцүүлж цол олгохыг нь болиод даваа болгонд цолтой болгоод ингээд явж байгаа юм.*

Тухайн үед хуулийн төслийг 2013.07.04-ний өдөр хэлэлцэх эсэх болон анхны хэлэлцүүлгийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, 2013.07.05-ны өдөр эцсийн хэлэлцүүлгийг хийж хуулийн төслийг 2 өдрийн дотор баталсан байдаг. Уг хуулийн төсөл батлагдснаар зохицуулалтгүй байсан Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын баяр наадамд түрүүлсэн арслан цолтой бөх ес давсан тохиолдолд олгох цолыг тодорхой зааж өгсөн.

Гэвч Монгол Улсын Ерөнхийлөгч 2013.07.08-ны өдөр Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд бүхэлд хориг тавьсан⁴⁶ бөгөөд Үндэсний их баяр наадмын тухай хуулийг олон улсын жишиг, өнөөгийн хөгжлийн чиг хандлагыг харгалзан нийт ард иргэдээр нээлттэй хэлэлцүүлж, мэргэжлийн байгууллагуудын саналыг авч, өргөн хүрээнд шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзсэн. Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал

⁴⁵ Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ. 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл. <http://www.parliament.mn/files/9854>

⁴⁶ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013.07.08-ны өдрийн Е/04 дугаартай захирамж. “Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хориг тавих тухай”

2013.07.09-ний өдөр хоригийг хүлээн зөвшөөрч⁴⁷, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль батлагдсан⁴⁸.

Ингээд мөн л Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын арслан цолтой бөх ес даван үзүүрлэх, 10 даван түрүүлбэл ямар цол олгох асуудал мөн зохицуулалтгүй үлдсэн. Хэрвээ 2016 онд 1024 бөх барилдсан үед арслан цолтой бөх 9 даван үзүүрлэсэн, 10 даван түрүүлсэн тохиолдолд ямар цол олгох нь тодорхойгүй үлдэх байсан.

Иймд 1024 бөх барилдах үед арслангаас дээш цолтой бөх үзүүрлэсэн, түрүүлсэн тохиолдолд ямар цол олгохыг тодорхой зааж өгөх хэрэгтэй бөгөөд уг харилцааг зохицуулсан дараах нэмэлт, өөрчлөлтийг хуульд оруулах саналтай байна.

Санал: “Улсын баяр наадамд 1024 бөх барилдсан тохиолдолд улсын баяр наадамд түрүүлсэн арслан цолтой бөх⁴⁹ 9 давсан бол үзүүр түрүүний өмнө түүнд улсын аварга цол олгож, улмаар 10 давж түрүүлбэл улсын даян аварга цол олгоно.

Улсын аварга цолтой бөх 9 давсан бол үзүүр түрүүний өмнө түүнд даян аварга цол олгож, улмаар 10 давж түрүүлбэл дархан аварга цол олгоно” .

Ингэснээр даваа бүрт цол олгох, цолны болзол хангасан бөхчүүдэд цолыг олгох, барилдааны даваа бүрийг өрсөлдөөнтэй болгож, бөхчүүдийн амжилтыг шударгаар үнэлэх боломж бүрдэх юм.

Ирэх 2021 онд Тулгар төрийн 2230, Их Монгол Улсын 815, Ардын хувьсгалын 100 жилийн ойн Үндэсний их баяр наадам болно. Түүхэн 100 жилийн ойн баяр наадамд 2048 бөх барилдахаар болбол цолыг хэрхэн олгох асуудлыг мөн тодорхой зохицуулах шаардлагатай байна.

2014 онд Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Батцогт, Б.Чойжилсүрэн нараас Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан Улсын Их Хуралд 2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн байдаг.

Хууль санаачлагчийн илтгэлд⁵⁰, Өнөөдөр Монгол үндэсний бөхийн хөгжил өндөр төвшинд хүрч өрсөлдөөн их болж байгаа нь үндэсний бөхийн даян болон дархан аварга төрөх боломжийг нэлээд багасгаж байгаа юм. “Далай аварга” цолыг хасах нь зүйтэй гэсэн олон түмний санал нь Монгол үндэснийхээ уламжлалыг хадгалах, мөн “даян”, “далай” аваргуудыг шинээр төрөх боломжийг бүрдүүлэх талаар ач холбогдолтой гэж олон түмний дунд санал, бодол ихээр яригддаг юм.

⁴⁷ Ерөнхийлөгчийн хоригийн тухай. 2013.07.09-ний өдрийн Монгол Улсын Их Хурлын 50 дугаар тогтоол. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2013 оны №28 дугаарт нийтлэгдсэн.

⁴⁸ Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль. 2013.07.09. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн. 2013 оны №28 дугаарт нийтлэгдсэн.

⁴⁹ Түүхэн уламжлал талаасаа улсын баяр наадамд түрүүлсэн бөхөд аварга цол олгох зарчим Үндэсний их баяр наадмын тухай хууль болон тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн агуулгад байсан болно. Б.Т.

⁵⁰ Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж 2014 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан. УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл.

<http://www.parliament.mn/files/2272>

Иймд шинээр олгогдох болсон улсын “далай аварга” цолыг олгодоггүй болгохоор хуульчлах саналыг хууль санаачлагчид бид оруулж байна гэжээ⁵¹.

Холбогдох байнгын хорооны санал, дүгнэлтэд⁵², 2003 онд шинээр “далай аварга” цол бий болгосон нь Монгол үндэсний бөхийн хөгжил, өрсөлдөөн өндөр төвшинд хүрч буй одоо үед уламжлалт “даян аварга”, “дархан аварга” цолонд хүрэх боломжийг хязгаарлаж байгааг үндэслэн хууль санаачлагчид шинээр бий болсон “далай аварга” цолыг хасахаар уг хуулийн төслийг боловсруулжээ. Төрийн байгуулалтын байнгын хороо уг хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно гэжээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд анхны хэлэлцүүлгээр хуулийн төслийг баталж, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д заасан “улсын аварга түрүүлсэн бол улсын далай аварга” гэсэн заалтыг хүчингүйд тооцож, 7.1.8-д заасан “улсын далай аварга” гэсний далай гэдгийг хассан байна.

Ингэснээр улсын даян аварга цолтой байсан А.Сүхбат болон Г.Өсөхбаяр нарт 2014 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “дархан аварга” цолыг нөхөн олгосон байдаг. Энэхүү цол олгосон жил дархан аваргуудын эрэмбийг доорх хүснэгтийн дагуу гаргасан байдаг⁵³.

№	Бөхийн нэр	Улсын наадмын даваа						Шөвгөрсөн нийт тоо
		10	9	8	7	6	5	
ДАРХАН АВАРГА								
1	Г.Өсөхбаяр	*	4	3	4	1	2	14
2	А.Сүхбат	1	2	*	3	4	1	11

2014 оны Тулгар төрийн 2223, Их Монгол улсын 808, Ардын хувьсгалын 93 жилийн ой, үндэсний их баяр наадамд дархан аварга А.Сүхбат⁵⁴, Г.Өсөхбаяр нар барилдсан.

А.Сүхбат би 2004 онд дархан аварга цолны болзлыг, Г.Өсөхбаяр 2009 онд дархан аварга цолны болзлыг хангасан тул Г.Өсөхбаяраас түрүүлж ам авна гэдэг, харин Г.Өсөхбаяр аварга Монголын Үндэсний бөхийн холбооноос гаргасан эрэмбийн дагуу би түрүүлж ам авна гэх маргаан гарч Үндэсний их баяр наадмын бөхийн барилдаан үргэлжлэн явагдах боломжгүй байдал үүсч байсан. Тухайн үед

⁵¹ Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ ашиг сонирхлын зөрчилтэй учраас чуулганы нэгдсэн хуралдаанд оролцохгүй гэж мэдэгдсэн бөгөөд чуулганы хуралдааны тэмдэглэлд үлдсэн байна

⁵² Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Су.Батболд танилцуулсан.

⁵³ 2015 онд Улсын цолтой 50-иас доош цолтой бөхчүүдийн шинэчилсэн эрэмбэ.

Засгийн газрын 2003 оны 7 дугаар сарын 04-ны өдрийн 164 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 3.5-д Бүртгүүлсэн бөхчүүдийн цол болон амжилтаар нь эрэмбэлсэн жагсаалтыг Монголын Үндэсний бөхийн холбоо тус тус гаргах бөгөөд энэ жагсаалтад ороогүй бөхийг барилдуулахгүй.

⁵⁴ Дархан аварга А.Сүхбат нь 2006 оноос хойш Үндэсний их баяр наадамд барилдаагүй байсан.

маргааныг шийдвэрлэх боломжгүй байдал үүссэн бөгөөд дархан аварга Г.Өсөхбаяр дархан аварга А.Сүхбатыг түрүүлж ам авахыг зөвшөөрч, асуудал түр хугацаанд шийдвэрлэгдэж, дархан аварга А.Сүхбат 3-ын даваанд дархан аварга Г.Өсөхбаярыг амлаж байсан.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8-д “Үндэсний бөхийн барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхчүүдийг цолны болон амжилтынх нь эрэмбээр тулгаж барилдуулах бөгөөд бусад даваанд дээрх эрэмбээр ам авч барилдана” гэж заасан бөгөөд А.Сүхбат, Г.Өсөхбаяр нарын хувьд даян аварга цолтой байх үед хуульд заасны дагуу Г.Өсөхбаяр нь түрүүлж ам авахаар байсан. Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7.9-д “Энэ хуулийн 7.8-д заасан амжилтын эрэмбээр ам авах заалт нь дархан аварга цолтонд хамаарахгүй” гэж заасан. Эндээс үзвэл дархан аварга цолтонд эрэмбийн асуудал хамаарахгүй нөхцөл байдал үүсч байна. Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор баталсан Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 2.4, 3.1, 3.2-т дээрх харилцааг зохицуулжээ.

Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 3.1-д “Бөхийн барилдааныг бөхчилсөн хэлбэрээр явуулах бөгөөд барилдааны нэг, хоёр, дөрвийн даваанд бөхийн цолны болон амжилтын эрэмбээр тулгаж, бусад даваанд дээрх эрэмбээр, дархан аварга цолтнууд цолны эрэмбээр ам авч барилдана” гэж заажээ. Уг заалтыг харвал Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 7.9-д заасан амжилтын эрэмбээр ам авах заалт нь дархан аварга цолтонд хамаарахгүй гэсэнтэй нийцэхгүй байна.

Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 3.2-т “Ижил цолтой бөхчүүд энэ дүрмийн 2.4.1⁵⁵, 2.4.2⁵⁶-т заасны дагуу тогтоосон эрэмбээр ам авна” гэж нарийвчлан зохицуулжээ. Уг заалтын дагуу ам авахад дүрмийн 2.4.1-д заасан цол, амжилтаар эрэмблэхэд хэд хэдэн эрэмбийн шалгуурыг тусгасан байна.

Дээрх нэг өдөр дархан аварга цолны болзол хангасан бөхчүүдийн хувьд цол, амжилтын эрэмбэ хамаарах уу? гэх асуудлыг Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулж чадаагүй байна. Мөн Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэмд энэ асуудлыг тодорхой ойлгомжтой байдлаар зохицуулаагүй байна.

⁵⁵ 2.4.1. ижил цолтой бөхчүүдээс тухайн цолны болзлоо олон биелүүлснийг, энэхүү нөхцөл ижил байвал доод давааг олон давсныг эхэнд нь эрэмбэлэх бөгөөд энэ жишгээр начин цолны даваа хүртэл тооцоход амжилт нь ижил байвал хэн түрүүлж одоогийн цолоо хүртсэн хугацаагаар, энэхүү нөхцөл мөн ижил байвал доод цолыг хүртсэн хугацааг тус тус харгалзаж эрэмбэлнэ;

⁵⁶ 2.4.2. нэг өдөр адил даваагаар ижил цол авсан бөхчүүдээс өмнөх цолоо түрүүлж авсан нь, энэхүү нөхцөл нь ижил буюу өмнө нь цолгүй байсан бол тулгаж барилдуулах жагсаалтад бичигдсэн дарааллаар эрэмбэлнэ. Ийнхүү эрэмбэ тогтоох боломжгүй бол шодож эрэмбийг тогтооно.

2.2. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэн эрхтэй холбогдох хэсэг

<p>Үнэлэгдэх хэсэг</p>	<p>12.4. Зохион байгуулах хороо нь баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.4.1. улсын баяр наадамд үзүүлсэн амжилтыг үндэслэн бөх, уяач, харваачид үндэсний спортын төрлөөр улсын цол олгох, хасах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх; 12.4.5.бөх, харваачийг энэ хуулийн 10.2-т заасан сэргээшийн шинжилгээнд оруулах ажлыг зохион байгуулах;</p>
<p>Томъёологдсон шалгуур үзүүлэлт</p>	<p>1.Зохион байгуулах болон салбар хорооны бүрэн эрх хэрхэн хэрэгжсэн бэ? 2.Сэргээшийн шинжилгээнд оруулах ажлын зохион байгуулалтын хэрэгжилт хангагдсан уу?</p>

Үнэлгээ:

1. Зохион байгуулах болон салбар хорооны бүрэн эрх хэрхэн хэрэгжсэн бэ?

Үндэсний баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэгт Зохион байгуулах хорооны бүрэн эрхтэй холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд 12 дугаар зүйлийн 12.4.1-д улсын баяр наадамд үзүүлсэн амжилтыг үндэслэн бөх, уяач, харваачид үндэсний спортын⁵⁷ төрлөөр улсын цол олгох, хасах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх, 12.4.5-д бөх, харваачийг энэ хуулийн 10.2-т заасан сэргээшийн шинжилгээнд оруулах ажлыг зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой гаргасан ҮИБНЗБХ-ны тогтоолтой холбоотой гомдлууд практикт гарч байна.

Тухайлбал, шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэрэг маргааны хувьд ҮИБНЗБХ-ны дараах шийдвэрүүдтэй холбоотой маргасан байна:

- Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны тогтоол гаргах бүрэлдэхүүнтэй холбоотой⁵⁸;
- Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо Хууль бус захиргааны акт гаргасан. Өөрөөр хэлбэл өөрийн чиг үүрэгт хамаарахгүй асуудлаар захиргааны акт гаргасан;

⁵⁷ Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “үндэсний спорт” гэж ард түмний уламжлал, зан заншилд тулгуурлан хөгжсөн үндэсний онцлог шинжийг агуулсан спортыг гэж тодорхойлсон. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2017.11.22-ны өдрийн №43 дугаарт нийтлэгдсэн.

⁵⁸ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015.11.16-ны өдрийн 0785 дугаартай шийдвэрийн нэхэмжлэгч тайлбартаа: Ардын хувьсгалын 93 жилийн ойн баяр наадмын Үндэсний быөхийн барилдаанд тав давж Монгол улсын ерөнхийлөгчийн 2014.07.12-ны 102 дугаар зарлигаар Улсын начин цол хүртсэн. Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо нь Засгийн газрын тогтоолоор бус Үндэсний их баяр наадмын тухай хуулиар байгуулагдсан байгууллага бөгөөд гагцхүү бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2012 он 98 дугаар тогтоолоор 28 гишүүнтэй байхаар тогтоосон. Гэтэл 2015.02.12-ны өдрийн хуралдаанд 16 гишүүд оролцсон нь Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны дүрмийн 2.2-д заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл 2015.02.12-ны өдрийн байдлаар Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолд өөрчлөлт ороогүй 28 гэж тогтоосон бүрэлдэхүүнийг 21 гишүүнтэй болгосон шийдвэр гараагүй байхад хуралдааны гуравны хоёр буюу 16 гишүүн оролцсон гэж тайлбарлаж байгаа нь үндэслэлгүй. Мөн нийт гишүүний гуравны хоёр хүрээгүй, хууль бус бүрэлдэхүүнтэй хуралдсан учраас уг тогтоол нь хүчин төгөлдөр бус юм.

- Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй тул хүчин төгөлдөр үйлчлэх эрх зүйн чадамжгүй;
- Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны тогтоол нь эрх хэмжээний хувьд зохион байгуулах хороонд хамааралгүй асуудлаар шийдвэр гаргасан, сонсох ажиллагаа хийгээгүй гэх мэт үндэслэлээр бөхчүүд шүүхэд нэхэмжлэл гаргаж, ҮИБНЗБХ-г хариуцагчаар татан оролцуулжээ.

Дээрх ҮИБНЗБХ-ны шийдвэртэй холбогдуулан гаргасан хэрэг маргаанд нэхэмжлэл гаргасан бөхчүүд нь бүгд сэргээш /допинг⁵⁹/ хэрэглэсэн болох нь итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон байдаг бөгөөд сэргээшийн шинжилгээний хариу, дүгнэлттэй холбоотойгоор маргасан тохиолдол дийлэнх олонхид байхгүй байв. Харин ҮИБНЗБХ-ны бүрэн эрхээ хэрэгжүүлэн гаргасан захиргааны актад⁶⁰ гомдол гаргаж байгаа практик байна.

Түүнчлэн, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.1 дэх заалтын хэрэгжилттэй холбогдуулан нэхэмжлэгч, хариуцагчийн тайлбар болон шүүхээс шийдвэрлэгдсэн тохиолдлоос судлан үзвэл Үндэсний баяр наадмын тухай хуулийн 12.4.1-т заасан “улсын баяр наадамд үзүүлсэн амжилтыг үндэслэн бөх, ... улсын цол олгох, хасах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх” гэж, Мөн Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм⁶¹”-ийн 9.3-т “... Салбар хороо дараах шийдвэрийг гаргаж тухайн бөхөд хариуцлага хүлээлгэнэ:

9.3.5.сэргээш хэрэглэсэн нь олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон бол тухайн бөхийн наадамд давсан давааг хүчингүй болгож, шинээр олгосон цолыг хураах, цол, чимэг авах даваанд уг бөхөд унасан бөхчүүдийг тухайн даваанд давснаар тооцож, зохих цол, чимгийг олгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх” гэж тус тус заасан байна.

Тохиолдол: Нэхэмжлэгч Э.Оюунболд нь Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо /ҮИБНЗБХ/-ны 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “Сэргээшийн шинжилгээний дүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 08 дугаар тогтоолын Э.Оюунболдод холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан.

Уг нэхэмжлэлийн агуулга нь: Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадамд барилдсан 512 бөхөөс 9 даван түрүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Улсын аварга цолыг хүртсэн. 2019 оны 10 сарын үед Баяр наадмыг зохион байгуулах хорооны зүгээс допинг хэрэглэсэн гэх үндэслэлээр Улсын аварга цолыг хураалгах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлж байгаагаа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан. Өмгөөлөгч тайлбартаа: “Үндэсний бөхийн

⁵⁹ Биеийн тамир, спортын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-т “допинг” гэж спортын үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглосон бодис, хориотой аргыг гэж тодорхойлсон. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2017.11.22-ны өдрийн №43 дугаарт нийтлэгдсэн.

⁶⁰ Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2015.07.24-ний өдрийн №28 дугаарт нийтлэгдсэн.

⁶¹ Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрэм.

<https://www.legalinfo.mn/annex/details/9895?lawid=13518>

дүрмийн 9.3 дугаар зүйлд дор дурдсан тохиолдолд Салбар хороо дараах шийдвэрийг гаргаж тухайн бөхөд хариуцлага хүлээлгэнэ гэж заасан дүрмийн 9.3 дугаар зүйлийн 5-д Сэргээш хэрэглэсэн нь олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон бол тухайн бөхийн наадамд давсан давааг хүчингүй болгож, шинээр олгосон цолыг хураах, цол, чимэг авах даваанд уг бөхөд унасан бөхчүүдийг тухайн даваанд давснаар тооцож, зохих цол, чимгийг олгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх гэж заасан. Цол, чимгийг хураах асуудал нь Салбар хорооны эрх мэдлийн асуудал байна” гэжээ.

Шүүхийн шийдвэр: Сэргээшийн шинжилгээний дүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 08 дугаар тогтоолыг гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр шийдвэрлэснийг хууль бус гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. Учир нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12.1, 12.4, 14.1.3-т тус тус зааснаар УИБНЗБХ шийдвэр гаргах эрхтэй байна⁶².

Дээрх шүүхээс шийдвэрлэсэн маргаанаас харахад Үндэсний их баяр наадмын бөхийн барилдааны дүрмээр УИБНЗБХ-ны бүрэн эрхэд хамаарах асуудлыг Үндэсний бөхийн салбар хорооны бүрэнд эрхэд хамааруулан хооронд нь давхцуулж, ойлгомжгүй байдал үүсгэж, практикт маргаан үүсэх шалтгааны нэг болсон нь харагдаж байна. Уг асуудлыг лавшруулан судалж эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Тиймээс Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн “9.3.5.сэргээш хэрэглэсэн нь олон улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр тогтоогдсон бол тухайн бөхийн наадамд давсан давааг хүчингүй болгож, шинээр олгосон цолыг хураах, цол, чимэг авах даваанд уг бөхөд унасан бөхчүүдийг тухайн даваанд давснаар тооцож, зохих цол, чимгийг олгуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхээр санал гаргах” гэж найруулах.

2.Сэргээшийн шинжилгээнд оруулах ажлын зохион байгуулалтын хэрэгжилт хангагдсан уу?

Нийгмийн харилцааг бүхэлд нь дан формаль хуулиар зохицуулах боломжгүй учир хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудыг батлан гаргадаг ба тэдгээр нь нийгмийн харилцааг мөн л зохицуулдаг тул “материаллаг хууль” хэмээн нэрлэх⁶³ нь ч бий.

Энэ утгаараа Засгийн газрын 2010 оны 119 дугаар тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс уг журмыг залгамжлан тухай харилцааг зохицуулж буй Захиргааны ерөнхий хуульд⁶⁴ захиргааны хэм хэмжээний актад тавигдах хууль зүйн шаардлагуудыг тодорхойлсон. Хэм хэмжээний актад тавигдах хууль зүйн хяналтыг хэрэгжүүлэх 2 үндсэн загвар байдаг. Үүнд, ерөнхий хяналт буюу захиргаа өөрөө (ихэвчлэн хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага) эсхүл хууль тогтоогч (эрхээ шилжүүлсэн этгээд гэдэг утгаар) тухайн хэм хэмжээний актыг хүчин төгөлдөр болж мөрдөгдөхөөс өмнө нь урьдчилан хуульд заасан нөхцөл,

⁶² Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/7046/view> Шүүхийн шийдвэрийг агуулгаар нь товчлов.

⁶³ Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал. УБ., 2005. 116 дахь тал.

⁶⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2015.07.24 №28 дугаарт.

шаардлагыг хангаж буй эсэхийг шалгаж, бүртгэх замаар хэрэгжүүлэх “*объектив хяналт*”, нөгөө нь хүний эрхийн зөрчил үүссэн эсэхийг шүүхээс тодорхой нэхэмжлэлд үндэслэн хэрэг маргааныг шийдвэрлэх замаар хэрэгжүүлэх “*субъектив хяналт*” буюу тодорхой хяналт юм. Захиргааны ерөнхий хуульд урьдчилан хяналтын зохицуулалт маш тодорхой тусгагдсаныг мөн хуулийн 61-67 дугаар зүйлээс харж болно. Харин тодорхой хяналтыг Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль болон хэм хэмжээний акт гаргах эрх олгогдсон тухайн хуулийн зохицуулалтад үндэслэн шүүх хэрэг маргааныг шийдвэрлэх замаар хэрэгжүүлэхээр⁶⁵ тусгасан.

ҮИБНЗБХ нь бүрэн эрхийнхээ хүрээнд 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 04 дугаартай тогтоолоор “*Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам*”-ыг шинэчлэн баталсан⁶⁶. Уг журам нь Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10.2, 12.4.5 дахь хэсэг болон Дэлхийн допинг /сэргээш/-ийн эсрэг агентлагаас баталсан “*Дэлхийн допинг /сэргээш/-ийн эсрэг дүрэм, олон улсын стандартыг үндэслэсэн баталсан байна*”⁶⁷.

Дээрх журам нь Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх харилцааг нарийвчлан зохицуулсан зохицуулалт юм.

Тохиолдол:

*1.Б.Ганзоригийн нэхэмжлэлтэй, ҮИБНЗБХ-нд холбогдуулан ҮИБНЗБХ-ны 2017.02.15-ны өдрийн “Сэргээшийн шинжилгээний дүгнэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 03 тоот тогтоолын Б.Ганзоригт холбогох хэсгийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэл*⁶⁸;

*2. Б.Суманчулуун, Н.Адьяабат нарын нэхэмжлэлтэй, ҮИБНЗБХ-нд холбогдуулан ҮИБНЗБХ-ны 2015.02.12-ны өдрийн хуралдааныг хууль бусад тооцож, хууль бус хуралдаанаас гаргасан 02 тоот тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг*⁶⁹ тус тус гаргасан байдаг.

Дээрх 2 нэхэмжлэлийн шаардлагад сэргээшийн шинжилгээ хийхийг удирдлага болгож буй Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам нь уг хэрэг маргааны шийдвэрлэх үед дагаж мөрдөгдөж байсан Засгийн газрын 2010 оны 119 дугаар тогтоолоор баталсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын 2.5.2-т “*Шийдвэрийг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ. Энэ шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн шийдвэрийг хүчин төгөлдөр бус гэж үзэж тухайн шийдвэрийг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хариуцлага хүлээлгэхгүй*”, мөн

⁶⁵ Ц.Цогт. Захиргааны хэм хэмжээний акт. <https://legaldata.mn/b/127>

⁶⁶ Уг тогтоолыг гарахаас өмнө ҮИБНЗБХ-ны 2007 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам мөрдөгдөж байсан.

⁶⁷ 1.Монгол Улс нь 2007 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын 2005 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Ерөнхий чуулганы 33 дугаар хуралдаанаар баталсан “Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц”-д Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсан. Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2007 он. 34 дугаарт нийтлэгдсэн.

2.Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор “Спортод сэргээшийн эсрэг Копенгагены Тунхаглал”-д Монгол Улс нэгдэн орохыг зөвшөөрсөн.

<https://www.legalinfo.mn/law/details/3704?lawid=3704>

⁶⁸ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр.

<http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3654/view>

⁶⁹ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр.

<http://shine.shuukh.mn/zahirgaaanhan/391/view>

журмын 1.9-д “*шийдвэрийг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ*” гэж заасан дээрх заалтуудыг зөрчсөн гэж маргажээ.

Гэвч 2015 болон 2017 онд шийдвэрлэгдсэн дээрх маргаануудын хувьд Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам нь бүртгэлгүй байсан тухай шүүхийн шийдвэрүүдэд тусгагдсан байна.

Харин шүүх уг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй журмыг практик хэрэглээний хувьд ижил агуулга бүхий 2 нэхэмжлэлийн хувьд хоёр өөр янзаар тайлбарласан байдаг. Үүнд:

1.Нэхэмжлэгч нарын “...бөхчүүдээс сэргээшийн шинжилгээ авч байгаа журам нь нийтээр дагаж мөрдөх захиргааны актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй ...хариуцлага тооцох үндэслэл үгүйсгэгдэнэ” гэх нэхэмжлэгчийн тайлбарыг няцаах үндэслэл тогтоогдохгүй байна гэж⁷⁰.

2.Хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэлгүй журмыг үндэслэн тогтоолыг гаргасан” гэж маргаж байх боловч энэхүү журам нь дангаараа маргаан бүхий захиргааны актын үндэслэл болоогүй, захиргааны байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас уг журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй нь маргаан бүхий тогтоолыг хүчингүй болгох үндэслэл болохгүй гэж⁷¹ ялгаатай байдлаар хоёр өөрөөр дүгнэж, тайлбарлаж шийдвэрлэжээ.

Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн явцад хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч /ҮИБНЗБХ/-ийн тайлбартаа хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад маргаан бүхий *Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журмыг* бүртгүүлэх хүсэлтийг гаргаж байсан. Гэвч хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын эрх бүхий этгээдээс тухайн журмыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй, бүх нийтээр дагаж мөрдөх үүрэггүй, хэсэг бүлэг хүмүүст зориулсан журам гэж тайлбарласан⁷² байдаг.

Тэгэхээр ҮИБНЗБХ-ны 2007 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан Бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдож, мөн 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 04 дугаартай тогтоолоор “*Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам*”-ыг шинэчлэн баталсан журам нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй талаарх мэдээлэл байхгүй байна.

⁷⁰ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 0785 дугаартай шийдвэрийн Үндэслэх хэсэг. 9 дэх тал.

<http://shine.shuukh.mn/zahirgaaanhan/391/view>

⁷¹ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 06 сарын 13-ны өдрийн 4682015 дугаартай шийдвэрийн Үндэслэх хэсэг. 9 дэх тал.

<http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3654/view>

⁷² Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан нь өөрөө салбар хорооны дарга хийж байсан бөгөөд энэ журмыг бүртгүүлэх шаардлагагүй гээд бүртгэж өгдөггүй байсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн албан бичиг нь уг журмыг бүртгэлгүй гэдгийг тодорхойлсон болохоос хэм хэмжээний акт мөн эсэх, бүртгүүлэх шаардлагатай, шаардлагагүй гэдгийг дурдаагүй гэдэг. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 06 сарын 13-ны өдрийн 4682015 дугаартай шийдвэрийн 5-6 дахь тал.

Иймд дээрх журам нь Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан Захиргааны хэм хэмжээний актын⁷³ шинжийг бүрэн агуулж буй тул заавал улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж, хүчин төгөлдөр үйлчилж, сэргээшийн шинжилгээ авах харилцааг зохицуулах тул бүртгэлгүй гэх шалтгаанаар дээрх нөхцөл байдлуудтай холбоотой хэрэг маргаан гарахыг үгүйсгэхгүй юм.

2.3.Бөхчүүдийг сэргээшийн шинжилгээнд хамруулахтай холбогдон гарч буй асуудал

Үнэлэгдэх хэсэг	10.2.Энэ хуулийн 7.1, 7.2-т заасан барилдааны шөвгийн 16-д үлдсэн бөх, ... сэргээшийн шинжилгээнд заавал оруулна.
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	1.Хуулийн зохицуулалтаар уг асуудлыг бүрэн зохицуулж чадсан уу? 2.Эмчилгээний зорилгоор сэргээшийн шинжилгээнээс чөлөөлөгдөх үндэслэл бий юу?

Үнэлгээ:

1. Дээрх хуулийн зохицуулалтаар уг асуудлыг бүрэн зохицуулж чадсан уу?

Эрх зүйн байдлын хувьд хуулийн зохицуулалтыг харвал Үндэсний баяр наадмын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасан барилдааны шөвгийн 16-д үлдсэн бөх нь сэргээшийн шинжилгээнд заавал хамрагдахаар хуульчилсан байна.

Гэвч 512 бөх барилдсан тохиолдолд шөвгийн 16-д үлдсэн бөхөөс сэргээшийн шинжилгээ авах үед хуулийн зохицуулалт хэрэгжих боломжтой байна. Харин 1024 бөх барилдсан тохиолдолд шөвгийн 16-д үлдсэн бөхөөс авна гэвэл 6 давсан бөхчүүд хамрагдахаар байна. Ингэхээр 5 давж шөвгөрсөн бөхөөс сэргээшийн шинжилгээ авахгүй байхаар харагдаж байна.

Тохиолдол: Б.Ганзориг нь Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороо ЛУИБНЗБХ/-ны 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн "Сэргээшийн шинжилгээний дүгнэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 03 тоот тогтоолын Б.Ганзоригт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан.

Уг нэхэмжлэлийн агуулга нь: Ардын хувьсгалын 95 жилийн ойн баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд 5 давж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 104 дүгээр зарлигаар "Улсын начин" цол хүртсэн. 2017.02.15-ны өдрийн "Сэргээшийн шинжилгээний дүгнэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 03 тоот тогтоолоор 5 давсан давааг хүчингүй болгож, улсын начин цолыг хасах саналыг Монгол Улсын ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх тухай тогтоолыг гаргасныг дараах үндэслэлээр зөвшөөрөхгүй байна:

- Үндэсний баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т зааснаар Б.Ганзориг нь шөвгийн 16-д биш 32-т үлдсэн учраас сэргээшийн шинжилгээ өгөх ёсгүй, хуулийн заалтад хамаарахгүй.

⁷³ Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.

Шүүхийн шийдвэр⁷⁴: Нэхэмжлэлийг хангаж шийдвэрлээгүй байна. Үндэсний баяр наадмын тухай хуулийг агуулгын хувьд авч үзвэл Улсын цол буюу 5 ба түүнээс дээш давсан бөхчүүдийг шөвгийн 16 болон 32-т үлдсэнээс үл хамаарч, сэргээшийн шинжилгээнд заавал хамруулах ёстой тул 10.2-т заасан хуулийн заалтыг шууд утгаар хуулийг хэрэглэх боломжгүй.

2017.01.25-ны өдрийн Засгийн газрын 27 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар Үндэсний их баяр наадмыг зохион байгуудах хорооны даргаар Монгол Улсын шадар сайд, орлогч даргаар Нийслэлийн Засаг дарга байхаар шинэчлэн баталсан байх тул гарын үсэг зурах эрхгүй этгээд гэж үзэх боломжгүй байна. Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1-д “Улсын наадмын үндэсний бөхийн барилдааныг Бөхийн салбар хороо хариуцан зохион байгуулна” гэж заасны дагуу Б.Ганзоригийн асуудлыг хэлэлцэх, шийдэрлэх ажиллагааг Үндэсний их баяр наадмын Үндэсний бөхийн салбар хороо 2017.02.09-ний өдөр хуралдаж шийдвэрлэсэн тул Захиргааны ерөнхий хуульд заасан сонсох ажиллагааг салбар хороон дээр хэрэгжүүлэхээр байна. Иймд сонсох ажиллагааг хийгээгүй гэх үндэслэлийг хүлээн авах боломжгүй байна.

Дээрх маргаанд Үндэсний баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д зааснаар “энэ хуулийн 7.1, 7.2-т заасан барилдааны шөвгийн 16-д үлдсэн бөх” гэж заасан. Хуулийн зохицуулалт нь агуулгаараа барилдааныг нэрлэсэн заалт болохоос уг барилдааны давааг нэрлэсэн заалт биш байж болох юм. Иймд хуулийн заалтыг шууд утгаар нь авч үзвэл 5 давсан боловч хуулийн хүрээнд шөвгийн 16-д биш, 32-т үлдсэн учраас шинжилгээ өгөхгүй байж болохоор зохицуулагдсан харагдаж байна. Хуулийн заалтыг агуулгаар нь үзвэл Улсын баяр наадамд барилдаж, улсын цол буюу 5 ба түүнээс дээш давсан бөхчүүдийг шөвгийн 16 болон 32-т үлдсэнээс үл хамаарч, сэргээшийн шинжилгээнд заавал оруулахаар зохицуулах шаардлагатай. Иймээс хуулийн зүйл, заалтыг шууд утгаар нь ойлгож, тухайн харилцааг бүрэн зохицуулсан байх ёстой.

Харин Үндэсний их баяр наадмын тухай хуулиар нарийвчлан зохицуулаагүй зохицуулалтыг Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор баталсан Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 15.1-т “Баяр наадмын бөхийн барилдаанд тав болон түүнээс дээш давж шөвгөрсөн бөхчүүд сэргээшийн шинжилгээнд заавал орно” гэж тодорхой зохицуулсан байна.

Иймд Үндэсний баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Санал: Үндэсний баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг “энэ хуулийн 7.1, 7.2-т заасан барилдаанд 5 давж шөвгөрсөн бөх...” гэж өөрчлөн найруулах.

2.Эмчилгээний зорилгоор сэргээшийн шинжилгээнээс чөлөөлөгдөх үндэслэл бий юу?

ҮИБНЗБХ нь 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 04 дугаартай тогтоолоор “Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журам”-ын 6.8-д Бөх, ... эрүүл мэндийн байдлын улмаас сэргээшийн эм зүйн ангилалд

⁷⁴ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр. <http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3654/view>

хамрагдах бодисыг хэрэглэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд (1) Монголын допингийн эсрэг төвийн дэргэдэх эмчилгээний зорилгоор чөлөөлөх комиссын дүгнэлт гаргуулах, (2) эмчийн дүгнэлтэд уг бодисыг ямар тунгаар, хэдий хугацаанд, ямар аргаар хэрэглэхийг Сэргээшийн эсрэг дэлхийн агентлагаас гаргасан стандартыг баримтлан тогтоож, өвчний түүхэнд тэмдэглэх, (3) эмчийн дүгнэлтийг Монголын үндэсний олимпын хороонд мэдэгдэж зөвшөлцсөний дагуу ... сэргээшийн эм зүйн ангилалд хамрагдах бодисыг хэрэглэх, (4) хориотой бодисын ангилалд хамрагдах бодис хэрэглэсэн бөх, харваач сорьц өгөхдөө энэ тухайгаа Ажлын хэсэгт мэдэгдэж, эмчийн дүгнэлт, өвчний түүхийн хуулбарыг шинжилгээний материалд хавсаргах.

Дээрх нөхцөлийг бүрэн биелүүлж, лабораторийн шинжилгээний хариунд тухайн эмийн бодисыг эмчийн дүгнэлтэд зааснаар хэрэглэсэн хэмжээтэй дүйцэх тунгаар хэрэглэсэн байвал сэргээш хэрэглэсэнд тооцохгүй байхаар журамласан.

Мөн “Эмчилгээний зорилгоор чөлөөлөх олон улсын стандартын 6.1-д “..тухайн тамирчин дараагийн тэмцээн эхлэхээс хамгийн багадаа 30 хоногийн өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ өгөх ёстой” талаар зохицуулсан байна.

Дээрх журам болон олон улсын стандартын хэрэгжилттэй холбогдуулан шүүхэд нэхэмжлэл гаргаж, хянан шийдвэрлэгджээ.

Тохиолдол: Ц.Бямба-Очирын нэхэмжлэлтэй Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хороонд холбогдуулан гаргасан нэхэмжлэлд⁷⁵ хориотой эмийг эмчийн жорын дагуу хэрэглэсэн мэдэх боломжгүй байсан гэсэн үндэслэлээр маргадаг.

Шүүхийн шийдвэр: УИБНЗБХ-ноос Ц.Бямба-Очирын цол хураах шийдвэрийг хүчингүй болгож барилдах эрхийг хоёр жилээр хасахаар шийдвэрлэснийг шүүхээс Үндэсний баяр наадам болохоос 30 Хоногийн өмнө аливаа эм, эмийн бэлдмэл хэрэглэсэн тухайгаа мэдүүлсэн тохиолдолд баяр наадамд барилдах эрх хязгаарлагдахгүй бөгөөд цол авсан, түрүүлсэн эсэх асуудал үгүйсгээлэхгүй. Мөн эмчийн жорын дагуу түүний буруугаас болоогүй буюу мэдээгүй тул нэхэмжлэгчийн цолыг дээрх үндэслэлээр хэвээр үлдээж барилдах эрхийг хоёр жилээр хасахаар шийдвэрлэснийг хэвээр үлдээсэн.

Иймд дээрх тохиолдолд Эмчилгээний зорилгоор сэргээшийн шинжилгээнээс чөлөөлөх олон улсын стандарт болон Үндэсний их баяр наадмын бөх, харваачид сэргээшийн шинжилгээ хийх журмыг нэг агуулгаар ойлгогдох байдлаар тодорхойлж, зохицуулах шаардлагатай байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуулиар зохицуулаагүй үндэсний спорттой холбоотой бусад харилцааг Биеийн тамир, спортын тухай⁷⁶ хуулиар зохицуулахаар хуульчилсан бөгөөд тус хуулийн 21 дүгээр зүйлд Допингийн⁷⁷ эсрэг үйл ажиллагаатай холбоотой асуудлыг зохицуулсан байна. Уг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн байгууллага, спортын холбоо бусад төрийн болон төрийн бус байгууллага нь хориглосон

⁷⁵ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.04.11-ний өдрийн 221/МА2019/0212 дугаартай магадлал. <http://new.shuukh.mn/zahirgaadavah/2948/view>

⁷⁶ Биеийн тамир, спортын тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 оны 43 дугаарт нийтлэгдсэн.

⁷⁷ Тус хуулийн 4.1.14-т “допинг” гэж спортын үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглосон бодис, хориотой аргыг гэж тодорхойлсон.

жагсаалтад багтсан бодис, аргууд, допингийн хор холбогдлын сурталчилгааг тогтмол зохион байгуулна гэж заажээ.

Биеийн тамир, спортын тухай хуульд заасан допингийн хор холбогдлын сурталчилгааг тогтмол зохион байгуулсан эсэх талаар Э.Оюунболд болон Ц.Бямба-Очирын шүүхэд гаргасан нэхэмжлэлд⁷⁸ ҮИБНЗБХ-нд холбогдуулан гаргасан нэхэмжлэлд тус тус дурдсан бөгөөд хуульд заасан “тогтмол” гэдэг нь ямар хугацааг ойлгох, ямар арга хэлбэрээр зохион байгуулах, хэрхэн баталгаажуулж авч байгаа нь тодорхойгүй тул уг асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

2.4. Үндэсний их баяр наадмын тухай хууль зөрчигч /бөх/-д хүлээлгэх хариуцлагатай холбогдох хэсэг

<p>Үнэлэгдэх хэсэг</p>	<p>14.1. Энэ хуульд заасан үүргийг зөрчсөн бөх, уяач, харваачид дараах шийтгэлийн аль нэгийг ногдуулна:</p> <p>14.1.1. тухайн баяр наадамд оролцуулахгүй байх буюу тухайн баяр наадмын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, үндэсний сурын харваанаас хасах;</p> <p>14.1.2. тухайн баяр наадмын бай, шагналыг олгохгүй байх;</p> <p>14.1.3. баяр наадамд оролцох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах.</p> <p>14.2. Энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан шийтгэлийг аймаг, сумын болон салбар хороо, 14.1.3-т заасан шийтгэлийг зохион байгуулах хороо тус тус ногдуулна.</p> <p>14.3. Энэ хуулийн 10.2-т заасан шинжилгээгээр бөх, харваач сэргээш хэрэглэсэн нь тогтоогдвол тухайн баяр наадамд олгосон цол, байрыг хасна. /Энэ хэсгийг 2007 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p>
<p>Томъёологдсон шалгуур үзүүлэлт</p>	<p>Хариуцлагын асуудлыг оновчтой зохицуулж чадсан уу?</p>

Үнэлгээ:

Хариуцлагын асуудлыг оновчтой зохицуулж чадсан уу?

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Энэ хуульд заасан үүргийг зөрчсөн бөх, ... дараах шийтгэлийн аль нэгийг ногдуулна: 14.1.1. тухайн баяр наадамд оролцуулахгүй байх буюу тухайн баяр наадмын үндэсний бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, үндэсний сурын харваанаас хасах; 14.1.2. тухайн баяр наадмын бай, шагналыг олгохгүй байх; 14.1.3. баяр наадамд оролцох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах” гэж заасан.

⁷⁸ Шүүх хуралдааны явцад гуравдагч этгээдээс: “Бөхчүүд Сэргээш хэрэглээгүй тухай батламж”-д гарын үсэг зурдаг. Уг батламжид: Хэрэв миний сорьцын лабораторийн шинжилгээнд жагсаалтад орсон бодис хэрэглэсэн тухай хариу гарвал Үндэсний их баяр наадмын тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан шийтгэл хүлээхэд гомдолгүй болохоо илэрхийлж байна. Мөн Тамирчны зөвшөөрлийн хуудасны 4-т “Дэлхийн допингийн эсрэг дүрмийн дагуу гаргасан шийдвэрээс үүссэн аливаа маргааныг Дэлхийн допингийн эсрэг агентлагийн дүрмийн 13 дугаар зүйлд заасны дагуу спортын арбитрын шүүхэд давж заалдах болно. Мөн хуудасны 5-д “дээр дурьдсан спортын арбитрийн шүүхийн давж заалдах шатны шийдвэр нь эцсийнх байх бөгөөд өөр бусад аливаа шүүхэд нэхэмжлэл гаргахгүй гэдгийг би хүлээн зөвшөөрч байна” гэж зурдаг.

Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Баяр наадамд оролцож буй бөх үндэсний бөхийн барилдааны дүрэмд заасан үүргийг биелүүлж, цээрийг сахих үүргийг хүлээнэ.” Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 178 дугаар тогтоолоор баталсан Үндэсний их баяр наадмын үндэсний бөхийн барилдааны дүрмийн 8.2-т бөхийн үүргийн талаар тусгасан. Тус нийтлэг үүрэг нь барилдааны дүрмийг судлан мэдэх, сахин биелүүлэх, бөхийн өмсгөлийн шаардлагад нийцсэн өмсгөл хэрэглэх, үзэгч олноо хүндэтгэх, барилдааны явцад хориглосон мэх хийх байхгүй талаар зохицуулсан.

Тэгэхээр Үндэсний их наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан хариуцлагад зөвхөн “үүрэг” зөрчсөн бол шийтгэл ногдуулах, мөн хуулийн тус шийтгэлийг аймаг, сумын салбар хороо болон зохион байгуулах хороо ногдуулахаар байна.

Харин онцолвол, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-т заасан “баяр наадамд оролцох эрхийг 2 жил хүртэл хугацаагаар хасах”, мөн хуулийн 14.3-т заасан “энэ хуулийн 10.2-т заасан шинжилгээгээр бөх ... сэргээш хэрэглэсэн нь тогтоогдвол тухай баяр наадамд олгосон цол, байрыг хасна” гэжээ.

Гэхдээ практикаас үзвэл дээрх хууль болон дүрэмд заасан үүргийг зөрчсөнөөс гадна сэргээш хэрэглэсэн бөхчүүдэд 14.1.3-т заасан шийтгэлийг ногдуулсан байна. Сэргээш хэрэглэхийг хориглох талаарх зохицуулалт хууль болон бөхийн барилдааны дүрэмд заасан үүрэгт тусгагдаагүй байна.

Практик болон шүүхээс шийдвэрлэсэн хэрэг маргаанд сэргээш хэрэглэсэн нь тогтоогдсон бөхчүүдэд Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14.1.3-т заасан шийтгэлийг ногдуулсан байна. Үүнд:

1. 2002-2009 он хүртэл сэргээш хэрэглэсэн 8 тохиолдол илэрсэн бөгөөд 2002 онд А.Сүхбат⁷⁹, 2003 онд Ду.Батбаяр⁸⁰, 2004 онд Д.Мягмарсүрэн, Г.Ганхуяг, 2006 онд Д.Рагчаа⁸¹, Г.Эрхэмбаяр, 2009 онд Ц.Сумъяабэйс, Соронзонболд⁸² нар юм.

⁷⁹ А.Сүхбатаас анаболик стероид гэх бодис илэрч, баяр наадмын Зохион байгуулах хорооноос түүний чимгийг хураах шийдвэр гарч байв. Тухайн үед А.Сүхбат нь улсын аварга цолтой байсан бөгөөд их шөвөгт шалгарсан билээ. Гэвч тэрбээр допингоо хүлээн зөвшөөрөөгүй учир шүүхэд хандаж, улмаар шүүхийн шийдвэр түүний талд гарсан юм. Ингээд А.Сүхбат аварга ямар ч шийтгэлгүй өнгөрсөн 2006 онд шинжилгээ өгөхөө татгалзсан бөгөөд ийм тохиолдолд мөн илэрсэнээр тооцдог байна.Хамгийн анх 2002 онд аварга А.Сүхбатаас допинг илэрсэн ч шүүх түүнийг буруугүй гэж үзсэн түүхтэй. А.Сүхбат нь улсын аварга цолтой байсан бөгөөд их шөвөгт шалгарсан билээ. Гэвч тэрбээр допингоо хүлээн зөвшөөрөөгүй учир шүүхэд хандаж, улмаар шүүхийн шийдвэр түүний талд гарсашн юм. Ингээд А.Сүхбат аварга ямар ч шийтгэлгүй өнгөрсөн. <https://koo.mn/p/883/> хамгийн сүүлд 2020.11.30-нд хандсан.

<http://analiz.mn/postview/12813> сүүлд 2020.11.30-нд хандсан.

⁸⁰ Ду.Батбаярын шинжилгээнээс сэргээш илэрч зохион байгуулах хороо түүний цолыг хураах шийдвэр гаргаж байв. Харин Ду.Батбаярын гомдлын дагуу шүүх авч хэлэлцээд хвчингви болгож байжээ. <https://bit.ly/2FjTwF> сүүлд 2020.11.30-нд хандсан.

⁸¹ Д.Рагчааг 2006 онд бус 2012 онд буруутайг нь тогтоож, түүнд унасан гэх Ц.Магалжавт заан, Ш.Уламбаярт харцага цол нөхөж олгосон түүхтэй. Энэ үед Д.Рагчаа заан цолтойдоо улсын баяр наадамд үзүүрлэж, гарьд цол нэмсэн тул нэг чимгийг нь хасаад л өнгөрсөн. <https://koo.mn/p/883/> сүүлд 2020.11.30-нд хандсан.

⁸² Үндэсний их баяр наадмаар 5 давж шөвгөрөн “Өсөх идэр” чимэг хүртсэн Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын харъяат, “Хилчин” спорт хорооны бөх, улсын заан Б.Соронзонболд, “Улам нэмэх” чимэг хүртсэн Завхан аймгийн Дөрвөлжин сумын харъяат, “Хүч” спорт хорооны бөх, улсын начин Ц.Сумъяабэйс нарын давааг хүчингүй болгон чимгийг нь хурааж, дээрх хоёр бөхөд унасан улсын заан Б.Ганбат, улсын харцага Д.Баасандорж нарт чимгийг нөхөн олгосон. <https://vip76.mn/content/8333> сүүлд 2020.11.10-нд хандсан.

Эдгээр бөхчүүдийн заримынх нь чимгийг хурааж, заримд нь ямар ч хариуцлага тооцож чадаагүй байдаг.

2.2009-2020 он хүртэл Үндэсний их баяр наадмын бөхийн барилдаанд сэргээшийн төрлийн бодис хэрэглэсэн бөхчүүдийн барилдах эрхийг 3 сараас 2 жил хүртэлх хугацаагаар хасч шийдвэрлэсэн байна. Үүнд:

2009 он: Б.Соронзонболд 1 жил;
2011 он: Г.Алтангэрэл 2 жил;
2011 он: Ц.Цогбаяр 2 жил;
2012 он: Х.Мөнхбаатар 3 сараар;
2012 он: Б.Сугаржаргал 6 сараар;
2016 он: Б.Баатарцол 2 жил;
2016 он: Б.Ганзориг 2 жил /цол хураасан/;
2018 он: Н.Ганбаатар 2 жил;
2018 он: А.Цацабшир 2 жил;
2018 он: Ц.Бямба-Очир 2 жил;
2019 он: Э.Оюунболд 2 жил хассан боловч Шүүхээс 2 жил хасах шийдвэрийг хүчингүй болгосон;
2019 он: Д.Цэрэнтогтох 2 жил.

3.2014 онд улсын начин цол хүртсэн Б.Суманчулуун, Н.Адъяабат, 2016 онд улсын начин цол хүртсэн Б.Ганзориг нарын цолыг хураах шийдвэр гарсан бөгөөд Б.Суманчулуун, Н.Адъяабат нарын барилдах эрхийг хасаагүй, харин Б.Ганзоригийн барилдах эрх, цолыг нь хураасан байдаг.

Гэвч 2012, 2018 онуудад улсын начин цол хүртсэн Б.Сугаржаргал, Ц.Бямба-Очир нарын цолыг хураагаагүй бөгөөд барилдах эрхийг 3 сар, 2 жилээр хасаад өнгөрсөн байна.

Бөхчүүдэд хариуцлага тооцсон дээрх арга хэмжээ нь харилцан адилгүй байгаа бөгөөд барилдах эрх хасах тухай хугацаа, цол хураах асуудлууд нь хууль, дүрэм болон журамд ямар тохиолдолд хэрхэн хэрэглэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Манай улсад бөхчүүдтэй холбогдон гарч буй шүүхээр шийдвэрлүүлж маргаануудын хувьд сэргээшийн төрлийн бодис хэрэглэсэн нь тогтоогдож түүнтэй холбогдуулан авсан арга хэмжээ болох захиргааны акттай холбоотой байдаг. Иймээс гадаад улсуудын хувьд сэргээш хэрэглэсэн тамирчинд ямар төрлийн хариуцлага ногдуулдаг талаарх туршлагыг судлан үзвэл⁸³:

1.Итали Улс

Итали Улсад 2000 оноос эхлэн допинг хэрэглэсэн асуудалд эрүүгийн хариуцлага тооцдог болсон. Хуулийн дагуу энэ хүрээнд багтах гурван төрлийн гэмт хэргийг ялгаж өгсөн.

- Эхний хоёр нь хэрэглэсэн тамирчин ба түүнд үйлчилж байсан ажилтануудад шууд хамааралтай. Допинг хэрэглэх, допинг хэрэглэхэд албадах болон тэмцээн уралдаанд давуу байдал олж авахын тулд спортод хэрэглэхийг хориглосон бодисуудтай холбоотой хууль бус үйлдэл хийсэн бол тамирчин, эмч, менежер гэсэн этгээдүүдэд гурван

⁸³ <https://zariq.mn/evq> сайтад байршуулсан гадаад орнуудын туршлагаас авав.

сараас гурван жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, 50 мянган еврогоор торгууль төлнө.

- 3 дахь төрлийн гэмт хэрэг нь хориотой эм бэлдмэлийн эрэлттэй холбоотой. Допинг худалдсан, тээвэрлэсэн, хадгалсан, зуучилсан хүмүүстэй холбоотой бөгөөд энэ үйлдлүүдийг хийсэн тохиолдолд 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэж, 80 мянган еврогоор торгоно.

2.Франц Улс

Францын спортын тухай кодекс болон бусад хууль журмын дагуу допинг хэрэглэсэн тамирчинд эрүүгийн хариуцлага тооцно. Спортын луйвар хийсэн, хийлгэсэн, нийлүүлсэн хүмүүсээс гадна энэ талын мөрдөн байцаалт явуулах үеэр хамтран ажиллахаас татгалзаж мэдүүлэг өгөхгүй гэвэл эрүүгийн хэрэг үүсгэн шийтгэх болмжтой. Допинг хэрэглэсэн хүнд 5 жил хүртэл хорих, 75 мянган еврогийн торгууль төлөх шийтгэл ноогдуулна. Допингтой холбоотой хэрэгт бүлэг этгээд ажиллаж байсан нь тогтоогдвол ногдуулах ял шийтгэлийн хэмжээг хоёр дахин нэмдэг.

3.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

2015 оноос эхлэн допинг хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага тооцдог болсон. Шинэ хуулиар допинг хэрэглэсэн, хадгалсан тохиолдолд тамирчин, эмч, албаны хүмүүс, дасгалжуулагчид нь гурван жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэж, торгууль ногдуулдаг. Мөн ХБНГУ-ын нутаг дээр допинг хэрэглэсэн гадаадын тамирчдад ч эрүү үүсгэн шийтгэдэг болсон. Допинг хэрэглэхтэй холбоотой бүлэг этгээд ажилласан, насанд хүрээгүй хүүхдийг допинг хэрэглэхийг албадсан бол хорих ялын хэмжээг 10 жил болж нэмэгддэг.

4.Испани Улс

Допинг хэрэглэсэн, тараасан, хууль бусаар худалдаалсан, өөрийн цусыг сэлгэх аргыг хэрэглэсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, хорих ялаар шийтгэдэг.

5.Кени Улс

Допингийн эсрэг дэлхийн агентлагаас хорьсон бодистой холбоотой хэрэгт холбогдвол гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэж, 30 мянган доллараар торгодог болсон. Мөн допингийн сорил өгөхөөс татгалзсан тамирчдыг 1 жил хүртэл хорих ялтай.

6.Оросын Холбооны Улс

2016 оноос эхлэн тамирчдыг допинг хэрэглэхэд албадсаны төлөө эрүүгийн хариуцлага тооцдог болсон. Тамирчныг допинг хэрэглэхэд албадсан албан тушаалтан, эмч, дасгалжуулагч болон бусад этгээдэд 5 мянган доллар хүртэл торгууль ноогдуулж эсхүл 1 жил хүртэл хугацаагаар хорих шийтгэл ноогдуулдаг. Допингтой холбоотой гэмт хэргийг бүлэг этгээд, урьдчилан тохиролцож үйлдсэн бол торгуулийн хэмжээг 8 мянган доллар болгож, давхар 1 жилийн хорих ял ногдуулна. Насанд хүрээгүй тамирчныг допинг хэрэглэхэд албадсан, хэрэглүүлэхийн тулд хүч хэрэглэсэн, сүрдүүлсэн бол 1 жилийн хорих ял ногдуулж, 8 мянган доллароор

торгоно. Харин тамирчинд мэдэгдэлгүйгээр сэргээш сэм өгч байсан нь тогтоогдвол 16 мянган доллароор торгож, 3 жилийн хорих ялаар хорино.

7.АНУ

Допингийн эсрэг дүрэм, журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага тооцдог. Хуулиар олон улсын чанартай спортод допинг хэрэглэх янз бүрийн арга мэх хэрэглэсэн нь нотлогдвол 1 сая доллараар торгож, 10 жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулна.

8.WADA-ийн байр суурь

Допинг хэрэглэсэн тамирчдад ногдуулдаг одоогийн систем нь үр дүнтэй байгаа тул эрүүгийн хариуцлага нь заавал байх ёстой шийтгэл гэж үзэхгүй байгаа. Өөрийн улсад тохирсон хууль батлах, Засгийн газрын хууль ёсны эрхэд хөндлөнгөөс оролцохгүй байх, допинг хэрэглэсэнд сэжиглэгдсэн тамирчдын зүгээс Олон улсын спортын арбитрын шүүхэд хандан давж заалдах эрхтэй гэж үздэг.

Мөн сэргээш хэрэглэсэн тамирчныг тэмцээн уралдаанд оролцох эрхийг хасах жилийн тоог хоёр байсныг дөрөв болгон нэмэгдүүлэхийг дэмжсэн. Иймд 4 жил хүртэл хугацаагаар тэмцээн уралдаанаас хасч⁸⁴ байгаа тул допинг хэрэглэхийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэхгүй байгаа аж. Гэхдээ WADA нь хориотой бодис үйлдвэрлэдэг, наймаалдаг тамирчид дамжуулан өгөх ажил хийдэг хүмүүсийн эсрэг илүү хатуу хууль батлахыг улс орнуудад хандан уриалсан байна.

Цаашид Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг хэрхэн ногдуулахыг тодорхой тусгах шаардлагатай байна. Сэргээшийн төрлийн бодис хэрэглэсэн тамирчдад хүлээлгэх хариуцлагын талаарх бусад улсуудын туршлага, шийтгэлийн арга хэмжээтэй харьцуулахад манай улсын хувьд хөнгөн шийтгэл ноогдуулдаг бөгөөд хариуцлага тооцох асуудлыг нарийвчлан зохицуулж өгөөгүй байна.

---ooOoo---

⁸⁴ WADA. Тамирчдад зориулсан олон улсын сэргээшийн эсрэг /2015/ хуулийн лавлагааны удирдамж. УБ., (2015), 20 дахь тал.